

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ЖИШЭЭН ДЭЭР АВЧ ҮЗЭХ НЬ





ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ЖИШЭЭН ДЭЭР АВЧ ҮЗЭХ НЬ
ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судлаач:

С.Оюунтуяа, МУИС-ийн докторант, хуульч

Улаанбаатар хот
2022 он

ННА 67.3
ДАА 340.009
О-634



**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР АВЧ ҮЗЭХ НЬ**

ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судлаач: С.Оюунтуяа, МУИС-ийн докторант, хуульч

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачийн хувийн дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

ISBN: 978-9919-9840-0-7

© Нээлттэй Нийгэм Форум, 2022

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс эрх зүйн зохицуулалтын чанарыг дээшлүүлэх, энэ үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр хууль тогтоомжид эрчимтэй шинэчлэл хийж байгаагийн дотор 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль онцгой байр суурь эзэлнэ. Тус хуулиар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсний үндсэн дээр үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл боловсруулах, улмаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, холбогдон гарах зардлын тооцоо хийх, төсөл боловсруулах явцдаа иргэн, төр, төрийн бус байгууллагаас санал авах үйл явцыг нарийвчлан зохицуулсан байдаг.

Тиймээс Хууль тогтоомжийн тухай хууль хэрэгжээд таван жил болж буйтай холбогдуулан судлаач С.Оюунтуяа энэ хуулийн хэрэгжилтийн үнэлгээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн жишээн дээр авч үзэн, хуулийн төсөл боловсруулах бүхий л үе шатанд тавигдах шаардлага хэрхэн хангагдсаныг судалсан болно. Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хууль тогтоомжийн үндэслэл, чанарыг сайжруулахад энэхүү судалгааны дүн зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Судлаач хуулийн үнэлгээг хийхдээ төсөл санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх хүртэлх үе шат бүрийг үнэлэх шалгуур асуултуудаас бүрдсэн үнэлгээний хуудас боловсруулсан нь цаашид Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний санаачилсан хуулийн төсөл боловсруулах үе шатыг үнэлэхэд арга зүйн нэгэн эх сурвалж болох нь дамжиггүй.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд бидний судалгааны ажилд Таны санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ	6
1.1. Үнэлгээний судалгааны үндэслэл, шаардлага	6
1.2. Судалгааны ажлын зорилго, хамрах хүрээ	9
1.3. Судалгааны арга зүй	11
ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАЛТЫН ҮЕ ШАТЫГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ДҮН	13
2.1. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх	13
2.2. Төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах	17
2.3. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	23
2.4. Төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх ...	28
2.5. Иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлж, санал авах	34
2.6. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах	39
2.7. Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	44
2.8. Төслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	48
ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН	54

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	58
--	----

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	66
----------------------------	----

ХАВСРАЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулах үйл явцын үнэлгээ	70
--	----

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат болон үнэлгээний судалгаанд хамаарах Хууль тогтоомжийн тухай хуулийн заалтууд	9
Хүснэгт 2.	Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангасан эсэх тухай мэдээлэл	50
Хүснэгт 3.	Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт (үе шат болон шалгах асуултын тоогоор)	55
Хүснэгт 4.	Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээний нэгдсэн дүн	56

График	Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, хувиар	54
--------	---	----

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

1.1. ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Манай улс сүүлийн жилүүдэд төрийн бодлого, шийдвэр гарах үйл явц дахь олон талын оролцоог хангах, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон хууль, тогтоомж батлан гаргаад байна. Үүнд, Хууль тогтоомжийн тухай, Нийтийн сонсголын тухай, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулиуд, мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн болон Захиргааны ерөнхий хууль зэргийг нэрлэж болно. Эдгээрийн нэг нь 2015 оны 5 дугаар сарын 29-нд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга бөгөөд 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн билээ.

Хууль тогтоомжийн тухай хуулиар¹

- Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах;
- Түүнд олон нийтийн оролцоог хангах;
- Хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхийг зорьж байгаа билээ.

Тус хуулийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах зорилгоор Засгийн газраас 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр “Аргачлал батлах” тухай 59 тоот тогтоол батлан гаргасан. Уг тогтоолоор дараах зургаан төрлийн аргачлалыг батлан хэрэгжүүлж байна:

¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 1.1 дэх хэсэг.

1. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал;
2. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал;
3. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал;
4. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал;
5. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал;
6. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал.

Тус хуулиар хууль, Улсын Их Хурал (УИХ)-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулахдаа ил тод, нээлттэй байх, олон нийтийн оролцоог хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг баримтлахаар тусгаж, хуулийн төсөл боловсруулах үе шатыг² дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах;
- Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах;
- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;
- Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;
- Хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах;

² Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл.

- Хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;
- Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Тус хуулийг баталснаас хойш нийт долоон удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэ явцад хууль, УИХ-ын шийдвэрийн төсөл боловсруулах үйл явц дахь олон талын оролцоог хумин, боловсруулах үйл явцын зарим үе шатыг хялбаршуулж, нэг үндсэн үе шатыг хүчингүй болгосон зэрэг нь хууль тогтоох үйл явцын үндэслэл, чанарыг сайжруулах замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх гэсэн хуулийн үндсэн зорилгоосоо зарим талаар ухарсныг харуулж байна.

Хууль тогтоомжийн тухай хууль хэрэгжиж эхлээд таван жил болж байгаа ч иргэний нийгэм, төрийн бус байгууллагаас мониторинг үнэлгээ, судалгаа хийж, хэрэгжилтийг үнэлсэн, энэ талаар системтэй ажигласан, хянасан, баримтжуулсан тохиолдол судалгааны явцад таарсангүй. Түүнчлэн тус хуулийн хэрэгжилтийг шаардан сайжруулах, хангуулахад зориулсан системтэй мэдээлэл, үнэлгээ зайлшгүй хэрэгцээтэй байхын зэрэгцээ төрийн бус байгууллагуудад энэ чиглэлээр туршлага хуримтлуулах, мэдээллээ солилцох шаардлага ч тулгамдаж байна.

Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг сонгон уг хуулийн төсөл боловсруулах үе шатыг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үнэлэх судалгааны ажлыг Нээлттэй Нийгэм Форумын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэлээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлж, 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг тус хуулиар зохион байгуулсан байна.

1.2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгаагаар Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхийг зорилоо. Хамрах хүрээний хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь авч үзээгүй бөгөөд зөвхөн хууль санаачлагчаас хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбоотойгоор 8 дугаар зүйлд заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат” болон тухайн үе шат бүрд хамаарах холбогдох заалтуудыг авч үзсэн болно (Хүснэгт 1-ийг харна уу).

*Хүснэгт 1. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат
болон үнэлгээний судалгаанд хамаарах
Хууль тогтоомжийн тухай хуулийн заалтууд*

Төсөл боловсруулах үе шат	Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд
Нэгдүгээр үе шат: Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах эсхүл Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх	13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах 51 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
Хоёрдугаар үе шат: Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах	14 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн үзэл баримтлалын төсөл боловсруулах 15 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг батлах
Гуравдугаар үе шат: Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	16 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах 22 дугаар зүйл. Хуулийн төслийн төрөл

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

	29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага 33 дугаар зүйл. Хуулийн төслийн танилцуулга
Дөрөвдүгээр үе шат: Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх	17 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх 18 дугаар зүйл. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох
Тавдугаар үе шат: Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах	38 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах
Зургаадугаар үе шат: Хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах	39 дүгээр зүйл. Төрийн байгууллагаас санал авах
Долоодугаар үе шат: Хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	21 дүгээр зүйл. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газрын санал, дүгнэлтийг авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх
Наймдугаар үе шат: Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу бүрдүүлбэрийг хангаж, УИХ-д өргөн мэдүүлэх	40 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр 41 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

1.3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

“Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх шалгах хуудас” боловсруулан, энэ дагуу сонгож авсан хуулийн төсөл батлах үе шат бүрийг үнэллээ. Тус үнэлгээний хуудас нь Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үе шат бүрийг үнэлэх нийт 94 асуулт бүхий найман хэсэгтэй. Шалгах асуултуудыг Хууль тогтоомжийн тухай хууль болон тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д үндэслэн боловсруулав.

Судалгааны аргачлалыг дараах байдлаар боловсруулсан. Үүнд:

- Үнэлгээний хуудасны үе шатуудыг үнэлэх хэсэг бүр “Шалгах асуултууд” болон “Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар” хэсгээс бүрдэнэ.
- Шалгах асуултад “Тийм”, “Үгүй” хариултын аль нэгийг сонгох ба хариулахад төвөгтэй болон тухайн шалгах асуултыг үнэлэхэд мэдээлэл, баримт хангалтгүй тохиолдолд “Хариулах боломжгүй” буюу “-” гэсэн тэмдэглэгээний аль ч хувилбарыг сонгосон, хариултын арын баганад байх “Тайлбар, үндэслэл” хэсэгт үндэслэл, шалтгаан, нотлох баримт, боломжтой тохиолдолд эх сурвалж зэргийг дурдаж өгсөн болно.
- “Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар” нь тухайн хэсгийн үнэлгээний үр дүнг нэгтгэн, өөрийн үнэлгээг дэлгэрүүлэн тайлбарлаж, дүгнэлт, дүн шинжилгээ хийсэн мэдээллээ оруулах хэсэг юм.
- Үнэлгээний хуудасны төгсгөл хэсэг нь Хууль тогтоомжийн тухай хуулийн үе шат бүрийг үнэлсэн үнэлгээг нэгтгэн гаргах юм. Энэ хэсгийг бөглөхдөө шалгах асуултын дагуу таван оноогоор үнэлэх ба үнэлгээгээ тав буюу “хангалттай сайн”,

дөрөв буюу “ерөнхийдөө хангалттай”, гурав буюу “дундаж”, хоёр буюу “хангалтгүй”, нэг буюу “огт хангалтгүй” гэсэн шатлалаар тохирох оноог дугуйлан, Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээг дундажлан тооцож гаргана.

Үнэлгээний шалгах асуултуудад хариулахдаа тухайн сонгож авсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл, түүнийг боловсруулах, өргөн мэдүүлэх үйл явцтай холбоотой баримт бичиг, тоо баримт, дүгнэлт, холбогдох талуудын санал, тайлан, уулзалтын болон хуралдааны тэмдэглэл, танилцуулга зэрэг бүхий л мэдээлэлд тулгуурласан болно. Эдгээр мэдээллийг дараах арга замаар цуглуулав. Үүнд:

- Хууль тогтоомжийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг цахим хувилбараар <http://forum.parliament.mn> сайтаас авсан.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэгтэй биечлэн танилцаж, зарим хэсгийг хуулбарлан авсан.
- УИХ, холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, баталсан тухай хуралдааны тэмдэглэл, Байнгын хорооны дүгнэлт, ажлын хэсэг байгуулсан тогтоол, харилцсан албан бичиг, холбогдох тайлан, судалгаа зэргийг <http://forum.parliament.mn> сайтаас авсан.
- УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх болон Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нартай цахим уулзалт зохион байгуулж, ярилцлага хийн мэдээлэл цуглуулсан.

Тус үнэлгээний хуудсыг зөвхөн хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатыг үнэлэхэд зориулан боловсруулсан бөгөөд хуулийн төслийн бүтэц, хэлбэр, зохицуулах зүйл, эх бичвэрт тавих шаардлагыг хамруулаагүйг дурдах нь зүйтэй.

Цаашид төрийн бус байгууллага, судлаачид Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ энэ “Шалгах хуудас”-ыг ашиглах боломжтой.

ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАЛТЫН ҮЕ ШАТЫГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ДҮН

2.1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх³ үе шатыг 13 шалгах асуултын дагуу үнэлэхэд хоёр асуултад “Үгүй” гэж хариулсан бөгөөд үлдсэн асуултыг үнэлэх боломжгүй байв. Үнэлгээний ерөнхий дүн нэг буюу “огт хангалтгүй”.

2.1.1. Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага

13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах

- 13.1. Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.
- 13.2. Энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалаар дараах асуудлыг судалж, зөвлөмж гаргана:
 - 13.2.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлах;
 - 13.2.2. тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох;
 - 13.2.3. тухайн асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох;

³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1 дэх хэсэг.

- 13.2.4. зохицуулах эрх зүйн хэм хэмжээний эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
- 13.2.5. хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох;
- 13.2.6. шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа хийх.

51 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

- 51.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал дараах агуулгыг хамаарна:
 - 51.1.1. хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах;
 - 51.1.2. хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох;
 - 51.1.3. зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох.
- 51.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.
- 51.3. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш таван жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.

Эндээс харахад хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”⁴-ын дагуу судалж,

⁴ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

зөвлөмж гаргахаар⁵, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”⁶-ын дагуу хийхээр байна.

2.1.2. Хуулийн шаардлага хангасан байдал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлаагүй байв. УИХ-д өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах ханалтын хуудас⁷ “Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1-д зааснаар шаардлагагүй” гэж тэмдэглэжээ.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайланг “Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас”⁸-нд “+” буюу “байгаа” гэсэн тэмдэглэлтэй байх ч холбогдох хувийн хэрэгтэй биечлэн танилцахад тус тайлан байгаагүй болно.

2.1.3. Дүгнэлт, тайлбар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлал хамаарахгүй байх гурван тохиолдол нэрлэснээс 12.3.1 нь “Тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан” гэсэн зохицуулалт байна. Харин “Тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан” гэдгийг ямар шалгуур баримтлан тогтоох нь эргэлзээтэй. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 21.4-т “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг **хуулиар тогтооно**”, 59.3-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр хурлын болон сум, дүүргийн хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох

⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл.

⁶ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт.

⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэг, 4 дэх тал.

⁸ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэг, 4 дэх тал.

⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1 дэх хэсэг.

журмыг хуулиар тогтооно” гэж тухайлан заасан. Гэтэл Үндсэн хуулийн 30, 31 дүгээр зүйлд ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, нэр дэвшүүлэх эрх, сонгуулийн үе шат, сонгууль хүчинтэй байх тохиолдол, дахин санал хураалт болон дахин сонгууль явуулах үндэслэл зэргийг дурдсан байх ч тухайлан Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1 болон дээр дурдсан бусад сонгуулийн адил “тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулах”-аар Монгол Улсын Үндсэн хуульд заасан тодорхой заалт байхгүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3-т “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш таван жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэжээ. Үндсэн хууль 1992 онд батлагдсанаас хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 1993 онд баталсан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар таван удаа, 2012 онд баталсан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар нэг удаа, харин 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 2015 онд баталсан Сонгуулийн тухай хуулиар тус тус зохион байгуулжээ. Эндээс дүгнэхэд Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явц, журмыг зохицуулж байсан Сонгуулийн тухай хууль батлагдан, хэрэгжээд таван жил болжээ. Тиймээс тус хуулийн төслийг батлах явцад Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хуулийн шаардлагыг хангаагүй гэж дүгнэх үндэслэл байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “Эдгээр сонгуулийг нэгдсэн нэг хуулиар¹⁰ зохион байгуулж явуулахад учирсан хууль хэрэглээний болоод зохион байгуулалтын хүндрэлтэй нөхцөл байдлууд нь сонгуулийн онцлог харилцааг тусгайлан зохицуулсан, зөвхөн тухайн сонгуульд үүсэж буй харилцааг зохицуулах хуулийн зохицуулалт, тусгайлсан хууль шаардлагатай болохыг харуулж байна” гэжээ. Өөрөөр хэлбэл, “хууль хэрэглээний” болон “зохион байгуулалтын хүндрэлтэй нөхцөл байдал” гэдгийг тогтоохдоо Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.2-т заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”¹¹-ын дагуу үнэлж,

¹⁰ 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан Сонгуулийн тухай хуулийг хэлж байна.

¹¹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт.

тухайн хууль тогтоомжийн “...хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийн, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх” боломжийг тодорхойлох ёстой. Ингэснээр Сонгуулийн тухай хууль нь Ерөнхийлөгчийг сонгохтой холбоотой харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хуулийн зорилго, зорилтоо хангаж чадсан эсэх, чадахгүй байгаа тохиолдолд шалтгааныг тодорхойлох, нийгэмд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөг тодорхойлон, засварлах болон сайжруулах, практикт гарсан хүндрэлүүд юу болох, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалт байсан бол түүнийг зохицуулах боломжтой хувилбарыг тогтоох замаар Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн чанарыг сайжруулахад ашиглах боломжтой байсан.

2.2. ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, БАТЛАХ

Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах¹² үе шатыг есөн шалгах асуултын дагуу үнэлэхэд найман асуултад “үгүй”, нэг асуултад “тийм” гэжээ. *Үнэлгээний ерөнхий дүн нэг буюу “огт хангалтгүй”.*

2.2.1. Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага

14 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах

14.1. Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

¹² Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.2 дахь хэсэг.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасан үзэл баримтлалын төсөлд дараах асуудлыг тусгана:

14.2.1. хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага;

14.2.2. хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;

14.2.3. хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;

14.2.4. хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.

14.3. Энэ хуулийн 14.2.1-д заасан үндэслэл, шаардлагад тухайн хууль тогтоомжийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг тодорхой тайлбарлаж тусгана.

15 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг батлах

15.1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн өөрийн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, батална.

15.2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж болно. Энэ тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвлөмж гаргана.

Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулах¹³

¹³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйл.

бөгөөд хуульд заасан дээрх асуудлыг тусгах шаардлагатай. “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага”-д тухайн хууль тогтоомжийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг тодорхой, дэлгэрэнгүй тайлбарлаж тусгана. Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн өөрийн санаачлах хууль тогтоомжийн үзэл баримтлалыг тодорхойлж батална. Үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж болох бөгөөд энэ тохиолдолд тус этгээд нь зөвлөмж гаргах үүрэгтэй байхаар зохицуулжээ.¹⁴

2.2.2. Хуулийн шаардлага хангасан байдал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулахаас өмнө хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлаагүй¹⁵, мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй¹⁶ талаар өмнөх хэсэгт авч үзсэн. Тиймээс үзэл баримтлал нь “...хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр боловсруулах” гэсэн хуулийн шаардлагыг хангахгүй байна. Мөн хуулийн төслийн үзэл баримтлалыг хэзээ баталсныг нотлох мэдээлэл байхгүй.

Төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг үзэл баримтлалд хангалттай, тодорхой тайлбарлаж¹⁷ тусгаагүй. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал¹⁸-ын 3.2-т заасны дагуу үндэслэл, шаардлагыг заахдаа харгалзан үзэж, дурдаж болох дөрвөн төрлийн асуудлыг тодорхой авч үзээгүй, хэтэрхий ерөнхий байдлаар тодорхойлжээ.

Үзэл баримтлалд хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тусгасан байх ёстой ч бодит байдал дээр хангалтгүй байна. Тухайлбал, хууль тогтоомжийн зорилгыг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг төсөөлөн төлөвлөөгүй¹⁹,

¹⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйл.

¹⁵ Үнэлгээний шалгах хуудасны 2.1-ийг харна уу.

¹⁶ Үнэлгээний шалгах хуудасны 2.2-ыг харна уу.

¹⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.3 дахь хэсэг.

¹⁸ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

¹⁹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3.7 дахь хэсэг.

ерөнхий бүтцийн хувьд Хууль тогтоомжийн тухай хууль²⁰, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал²¹-д дурдсан наад захын “...урьдчилан төсөөлж болох хамгийн ерөнхий бүтцийг гаргах” шаардлагыг хангаагүй, зохицуулах харилцаа, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлоогүй, хэтэрхий ерөнхий, бүрхэг тусгажээ.

Үзэл баримтлалд хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар тусгах ёстой ч хэтэрхий ерөнхий, ажил хэрэгч бус, дутуу буюу иж бүрэн, тодорхой тайлбарлаж тусгаагүй, холбогдох аргачлалын дагуу цогц байдлаар авч үзээгүй байна.²² Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, эдгээртэй холбоотой авч хэрэгжүүлэх санал зэргийг бүхэлд нь нэг өгүүлбэрт багтаан томъёолжээ. Тухайн хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр гарах зардлын тооцоог холбогдох аргачлалын дагуу хийсэн атал энэ талаарх тоо, мэдээллийг үзэл баримтлалд тусгаагүй байв.

Үзэл баримтлалд хууль тогтоомжийн төсөл нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах талаарх санал тусгагдах ёстой. Гэтэл үзэл баримтлалд энэ тухай огт дурдаагүй, орхигдсон гэж хэлж болохоор байна. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна” гэснээс өөр мэдээлэл байсангүй.

Үзэл баримтлалд хууль хэрэгжүүлэхэд шаардлагатай шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хууль тогтоомжийн талаар тусгасан эсэхийг лавлаж үзэхэд зөвхөн “...Сонгуулийн тухай хуулийн Ерөнхийлөгчийн сонгуулийн харилцааг зохицуулж байсан бүлэг бүхэлдээ хүчингүй болно” гэснээс өөр мэдээлэл байхгүй. Зүй нь шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаар

²⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.1 дэх хэсэг.

²¹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3 дахь хэсэг.

²² 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.4 дэх хэсэг.

“...ямар хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, ямар хуулийг хүчингүй болсонд тооцох шаардлагатай байгааг судалж, хуулийг нэрээр нь тодорхой заана”²³ гэсэн байгаа ч Сонгуулийн тухай хуулиас өөр ямар ч хуулийг нэрлэн заагаагүй байв. “Холбогдох хуулийн төслүүдийг хамтад нь боловсруулна” гэснээс өөр мэдээлэл алга байна. Хуулийн төсөл нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдаж байгааг тодорхойлох, эрх зүйн тогтолцоонд тухайн хуулийн эзлэх байр суурь, ямар хуулийн салбарт хамаарах, хуулийн төсөл батлагдан гарснаар тухайн салбарын хууль тогтоомжид гарах үр нөлөө, ач холбогдлыг тусгах зэрэг “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”²⁴-д байгаа шаардлагыг хангаагүй байна.

2.2.3. Дүгнэлт, тайлбар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”²⁵-ын 3.2.1-д зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, энэ үнэлгээний үр дүнд үндэслэн үзэл баримтлал боловсруулах ёстой. Гэтэл сонгож авсан хуулийн төслийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.1-д заасан “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна” гэснийг баримтлаагүй байна.

Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг үзэл баримтлалд тусгахдаа “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”²⁶-ын 3.2.2, 3.2.3, 3.2.4, 3.2.5-д заасны дагуу тухайн хууль батлах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг нотолсон эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон холбогдох байгууллагуудаас гаргасан санал дүгнэлтийг харгалзан үзэж тусгах, хууль тогтоох чиглэлээр төрийн дээд байгууллагаас гаргасан бодлогын баримт бичгийг дурдах, Монгол Улсын олон улсын гэрээний хэм хэмжээнд

²³ Дээрх аргачлалын 3.5.3 дахь хэсэг.

²⁴ Дээрх аргачлалын 1 дүгээр бүлгийн 3.5 дахь хэсэг.

²⁵ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

²⁶ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

нийцүүлэх шаардлага гарсныг заах эсвэл хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийснээр тухайн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага байгааг тодорхойлсон санал зөвлөмжийг үндэслэл болгох боломжтой. Төслийн үзэл баримтлал хэсэгт үндэслэл, шаардлагыг “...сонгуулиудыг нэгдсэн нэг хуулиар зохион байгуулж явуулахад учирсан хууль хэрэглээний болоод зохион байгуулалтын хүндрэлтэй нөхцөл байдлууд нь сонгуулийн онцлог харилцааг тусгайлан зохицуулсан, зөвхөн тухайн сонгуульд үүсэж буй харилцааг зохицуулах хуулийн зохицуулалт, тусгайлсан хууль шаардлагатай болохыг харуулж байна. Иймээс Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах ерөнхий шаардлага зэргийг харгалзан Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох тусгайлсан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, түүнчлэн Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах зэргээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох шаардлага үүсэж байна” гэж тодорхойлсон нь аргачлалд дурдсан шиг биш, хэт ерөнхий, тоймлосон байдалтай байна.

Үзэл баримтлалын “Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц” хэсэг нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахгүй, хэтэрхий ерөнхий, зарим хэсэг нь хоорондоо зөрчилтэй томъёологджээ. Үзэл баримтлалын “Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага” хэсэгт Сонгуулийн тухай хууль буюу бүх сонгуулийг нэгдсэн нэг хуулиар зохион байгуулж байгаа нь хүндрэл үүсгэж байгаа тул “тусгайлсан хууль шаардлагатай” гэж хэрэгцээг тодорхойлсон ч “Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц” гэсэн хоёр дахь хэсэгт “...Сонгуулийн тухай хуулийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой харилцааг зохицуулсан суурь зохицуулалтуудад үндэслэн, түүний үзэл баримтлалын хүрээнд боловсруулна” гэсэн нь агуулгын хувьд зөрчилтэй харагдлаа.

Үзэл баримтлалын гурав дахь хэсэгт эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар “Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулах эрх зүйн орчин боловсронгуй болж, хууль хэрэглээний болоод зохион байгуулалтын хувьд нэг мөр, ойлгомжтой болохоос гадна хууль хоорондын уялдаа хангагдаж хэрэгжилтийг нэг мөр хангах нөхцөл бүрдэнэ” гэж нэг өгүүлбэрт багтаан тодорхойлжээ. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 3.4-т энэ хэсгийг боловсруулахад авч үзэх ёстой шаардлага, тайлбарлаж оруулах мэдээллийг заасан, мөн “хуулийн төслийг баталж хэрэгжүүлснээр гарах үр дүнг тусгайлан заана”²⁷ гээд “хүрэх үр дүнг заахдаа хэт ерөнхий байдлаар бичихээс зайлсхийх” гэснийг анхаарч үзээгүй, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль санаачлагчдын нэг нь баталжээ. Хуулийн хувийн хэрэгт байгаа материалууд болон төслийн үзэл баримтлалын гурав дахь нүүрний төгсгөл хэсэгт “Хууль санаачлагчид” гэж бичсэн зэргээс харахад уг хуулийн төслийг нэг биш гишүүн санаачилсан нь харагдана. Харин хуулийн төслийг хэд хэдэн гишүүн хамтран санаачилбал үзэл баримтлалыг хэрхэн батлах талаар нарийвчилсан зохицуулалт Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох аргачлалд байхгүй байгааг анхаарах шаардлагатай.

2.3. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах²⁸ үе шатыг 17 шалгах асуултын дагуу үнэлэхэд 12 асуултад “үгүй”, гурван асуултад “тийм” гээд хоёр асуултад албан ёсны мэдээлэл олдоогүй тул хариулаагүй. *Үнэлгээний ерөнхий дүн хоёр буюу “хангалтгүй”.*

2.3.1. Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага

Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлд хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбоотой шаардлагыг нарийвчлан тусгасан.

²⁷ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.4.6 дахь хэсэг.

²⁸ Хууль тогтоомжийн 8.1.3 дахь хэсэг.

16 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

- 16.1. Хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна.
- 16.2. Хууль тогтоомжийн төслийг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон 12.1.1-д заасан аргачлалын дагуу боловсруулна.
- 16.3. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна.
- 16.4. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийн төсөл боловсруулах талаар төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч болно.

33 дугаар зүйл. Хуулийн төслийн танилцуулга

- 33.1. Хууль санаачлагч хуулийн төслийн танилцуулга бэлтгэнэ.
- 33.2. Хуулийн төслийн танилцуулгад дараах мэдээллийг тусгана:
 - 33.2.1. хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтын талаар;
 - 33.2.2. тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал;
 - 33.2.3. хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
 - 33.2.4. хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн;
 - 33.2.5. гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт.

Тус хуулийн 33.1-д “Хууль санаачлагч хуулийн төслийн танилцуулга бэлтгэнэ”²⁹ гээд хуулийн төслийн танилцуулгад дээрх мэдээллийг багтаахаар³⁰ зохицуулсан нь энэ үе шатанд хамааралтай.

²⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.1 дэх хэсэг.

³⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.2 дахь хэсэг

2.3.2. Хуулийн шаардлага хангасан байдал

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”³¹-д заасан “...танилцуулга нь хуулийн төслийн үзэл баримтлалын тухай биш харин хуулийн төслийн тухай” байх, “...танилцуулгыг боловсруулахдаа үзэл баримтлалыг хуулбарлан давхардуулж бичихгүй” байх зэрэг шаардлагыг хангаагүй байна. Төслийн үзэл баримтлалын “Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага” гэсэн нийт таван параграфын танилцуулгад үг, үсгийн зөрүүгүй хуулбарлан тавьсан, үлдэх хоёр параграф нь “Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц” гэсэн хэсгээс мөн хуулбарлан авчээ. Танилцуулгад төслийн үзэл баримтлалаас ялгаатай ганц өгүүлбэр байгаа нь “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл нь 11 бүлэг, 81 зүйлтэй бөгөөд төслийн үзэл баримтлалд заасан үндэслэл, шаардлагын дагуу боловсрууллаа” гэжээ. Танилцуулга нь хуулийн төсөл боловсруулсны дараа бичигддэг. Гэтэл танилцуулгад төсөлд тусгасан зарчмын шинэлэг зохицуулалтыг³² “дэлгэрэнгүй тайлбарлах”³³ хууль тогтоомжийн шаардлагууд хангагдаагүй байна.

Төслийн танилцуулгын бичвэрийн бүтцийн стандартыг хангаж буй байдлыг авч үзэхэд хуулийн төслийн танилцуулгын эхний хуудсанд “ТАНИЛЦУУЛГА” гэсэн үгийг бичвэрийн дээд талд том үсгээр голлуулан бичих, дараагийн мөрний зүүн доод өнцөгт хуулийн нэрийг тухайлан бичиж, төгсгөлд нь хууль санаачлагчийн нэрийг тавих³⁴ зэрэг шаардлагыг хангаагүй байна.

Хуулийн төслийн агуулга нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх ёстой. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланд “Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж, ойлгомжгүй байдал үүсгэж буй, төслийн зохих хэсэгт тусгаагүй зүйл,

³¹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 7.4 дэх хэсэг.

³² Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэг.

³³ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 7.3 дахь хэсэг.

³⁴ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 7.5 дахь хэсэг.

заалт хэд хэд байна³⁵, “Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой уялдаагүй заалт хэд хэд байна”³⁶ гэжээ. Тухайлбал, төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “арван найм, дөчин таван нас хүрсэн” гэсэн нэр томъёог тодорхойлон тусгасан хэдий ч нэр дэвшигчийн тухайд энэ тодорхойлолт нь Монгол Улсын Үндсэн хууль болон хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт тусгасан зохицуулалттай зөрчилдөхөөр байна. Түүнчлэн төслийн 57 дугаар зүйлийн 57.1-д сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07.00-20.00 цагийн хооронд авахаар, төслийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт гадаад улсад байгаа сонгогчийн саналыг тухайн орон нутгийн цагаар 07.00-22.00 цагийн хооронд авахаар тусгасан нь хуулийн тэгш байдлын зарчмыг алдагдуулж, иргэдэд ялгавартай хандсан зохицуулалт болсон гэж үзэж болохоор³⁷ байна. Түүнчлэн ерөнхийлөгчид бие даан нэр дэвших эрхийг хуулиар зөвшөөрдөггүй, парламентад суудалгүй улс төрийн намууд оролцох боломжгүй байгаа зэрэг нь Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактаар хүлээсэн үүрэг, хэм хэмжээтэй зөрчилдөж байна.³⁸

Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан эсэхийг нягталж үзэхэд хуулийн төсөлд сонгуулийн анхан шатны санал хураалтын үед сонгуулийн сурталчилгаа зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан атал хоёр дахь санал хураалт явуулах тохиолдолд сурталчилгааг хэрхэн явуулах талаарх зохицуулалтыг тусгаагүй.³⁹

³⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 49 дэх тал.

³⁶ Мөн тэнд, 50 дахь тал.

³⁷ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 50 дахь тал.

³⁸ Тус Пактын 25 дугаар зүйлийн тухай НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан 25 дугаар Ерөнхий тайлбарын 15 дахь хэсэгт “Сонгогдох эрх эдлэх боломжгүй хүмүүсээс бусад хүн боловсрол, оршин суугаа газар, гарал үүсэл эсвэл улс төрийн харьяаллын шалтгаан гэх мэт үндэслэлээр ялгаварлан гадуурхагдах ёсгүй” хэмээн заасан байдаг.

³⁹ Энэ талаар 2017 оны Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хорооны сүүлийн тайлангийн 14 дэх талд “Сонгуулийн тухай хуулиар зөвхөн сонгуулийн анхан шатны санал хураалтын үед сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Харин сонгуулийн хоёр дахь санал хураалтын үеэрх сонгуулийн сурталчилгааны тухайд хуулийн хийдэл байгаа нь ажиглагдав” гэжээ.

Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт хооронд зөрчилгүй байх шаардлагыг хангаж буй эсэх талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдөж болзошгүй хэд хэдэн тохиолдол илэрсэн⁴⁰ гэжээ. Тухайлбал, төслийн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцээгүй⁴¹, нэр томъёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томъёотой нийцэхгүй⁴², төсөлд тусгагдсан зарим зүйл, заалт нь хуулийн төслийн болон бусад хуультай нийцээгүй⁴³ талаар мэдээлэл байна.

2.3.3. Дүгнэлт, тайлбар

Төслийн танилцуулга нь үзэл баримтлалыг хуулбарлаж, давхардуулахгүй байх ёстой ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулгын бараг 99 хувь буюу нийт найман параграфын долоо нь хуулийн төслийн үзэл баримтлалтай яг давхажжээ. Хуулийн төслийн танилцуулга нь үзэл баримтлалаа хуулбарласан тул тухайн хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалтын талаарх мэдээллийг хангалттай, дэлгэрэнгүй өгч чадахааргүй байна. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн, гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний дүгнэлт зэрэг мэдээллийг төслийн танилцуулгад огт тусгаагүй, орхигдуулжээ.

Хуулийн төслийн танилцуулгад тусгах ёстой мэдээллийн “тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал” хэсгээс бусад нь тусгагдаагүй, танилцуулгын бичвэрийн ерөнхий бүтэц, стандартыг холбогдох аргачлалд нэг бүрчлэн тодорхойлсон байтал үүнийг огт баримтлаагүй байна.

⁴⁰ Мөн тэнд, 32 дахь тал.

⁴¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 50 дахь тал.

⁴² Мөн тэнд, 50 дахь тал.

⁴³ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 51 дэх тал.

“Төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах” хэсэгт⁴⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн “үзэл баримтлалыг хуульд заасан шаардлагын хүрээнд боловсруулах”, “төсөл боловсруулах үндэслэл шаардлагыг хангалттай, тодорхой тайлбарлаж тусгах”, “үзэл баримтлалд хууль тогтоомжийн зорилгыг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг төсөөлөн төлөвлөх”, “урьдчилан төсөөлж болох хамгийн ерөнхий бүтцийг гаргах” зэрэг Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан наад захын шаардлагыг хангаагүй байсан тул уг хуулийн төсөл үзэл баримтлалын хүрээнд боловсруулагдсан эсэхийг үнэлэх боломж хязгаарлагдсан.

Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төсөл боловсруулаагүй байгаа⁴⁵ нь “хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулсан байх” хуулийн шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүйг харуулж байна.

2.4. ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, ЗАРДЛЫН ТООЦООГ ХИЙХ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх⁴⁶ үе шатыг 12 шалгах асуултын дагуу үнэлэхэд дөрвөн асуултад “үгүй”, долоон асуултад “тийм” гээд нэг асуултад албан ёсны мэдээлэл олдоогүй тул хариулаагүй. *Үнэлгээний ерөнхий дүн гурав буюу “дундаж”.*

⁴⁴ Үнэлгээний хуудасны 3 дахь хэсгийг үзнэ үү.

⁴⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 33 дахь тал.

⁴⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.4 дэх хэсэг.

2.4.1. Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага

17 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх

- 17.1. Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үнэлнэ.
- 17.2. Энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлж, зөвлөмж гаргана */Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*:
- 17.2.1. хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх;
- 17.2.2. хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;
- 17.2.3. хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох.
- 17.3. Хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг тооцсоны үндсэн дээр шаардлагатай бол тухайн хууль тогтоомжийн төсөл эсхүл түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулна.

18 дугаар зүйл. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох

- 18.1. Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.
- 18.2. Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах болон энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалыг баримталж болно.

Хууль санаачлагч “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу хууль тогтоомжийн төслийг үнэлж, зөвлөмж гаргана.⁴⁷ Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тодорхойлно.⁴⁸ Мөн хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах⁴⁹ болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ⁵⁰ “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримталж болно.

2.4.2. Хуулийн шаардлага хангасан байдал

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ”-г хууль санаачлагчийн захиалснаар 2019 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс гүйцэтгэсэн байна. Тус тайлан нь “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”⁵¹-ын 1.4 дэх хэсэгт заасан үе шат, 2.2 дахь хэсэгт заасан үр нөлөөг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтийн төрөл тус бүрийг⁵² багтаасан, 5.1 дэх хэсэгт заасны дагуу үр нөлөөг үнэлсэн үр дүнг баримтжуулан үнэлж, холбогдох зөвлөмжийг багтаасан⁵³, хууль тогтоомжийн төсөл, түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилсэн, төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах асуудлыг багтааснаас гадна батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан

⁴⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл.

⁴⁸ Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйл.

⁴⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл.

⁵⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл.

⁵¹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

⁵² “2.2.5. зардал” гэсэн хэсгийг эс тооцвол. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол”-ыг тусад нь хийсэн байгааг энэ хэсгийн 5.2-оос харах боломжтой.

⁵³ Энд үр нөлөөг үнэлсэн тайлангийн чанарын асуудлыг хөндөөгүй болохыг тусгайлан тэмдэглэж байна.

тооцоолоогүй үр дагаврыг тодорхойлох⁵⁴ зэргээр хуульд заасан шаардлагын дагуу үнэлгээ хийгджээ. Тухайлбал, Төрийн аудитын дээд байгууллагаас нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргахаар тогтоосон хугацаа нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг авч үзээд нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хуульд нийцээгүй тохиолдолд алдааг засуулан дахин дүгнэлт гаргах, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх зэрэгт 10 хоног байгаа нь⁵⁵ олон улсын стандартын дагуу аудит хийх боломжит хугацаатай нийцэхгүй байгаа талаар дурджээ. Түүнчлэн төсөл батлагдан хэрэгжсэнээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоолоогүй үр дагаврыг “Өмнөх сонгуулийн хууль тогтоомжид байсан УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжин оролцож болох тухай зохицуулалтыг хассан боловч хориглоогүй байгаа нь практикт эргэлзээтэй байдал үүсгэхээр байна. Сонгуулийн хороод хамтын удирдлагатай бөгөөд эрх хэмжээнийхээ асуудлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон хуралдаанаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэдэг тул бүрэлдэхүүний тоог тодорхой, сондгой тоогоор тогтоох нь зүйн хэрэг юм. Гэтэл төслийн зохицуулалтад “5-7” гэснээр бүрэлдэхүүний тоо “6” ч байж болохоор ойлгогдож байна”⁵⁶ гэж тодорхойлжээ.

Шаардлагатай бол тайлангийн үр дүнд үндэслэн тухайн хууль тогтоомжийн төсөл, түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулах ёстой ч энэ ажиллагаа хийгдээгүй байна. Тухайлбал, хуулийн төсөлд нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө төрийн аудитын байгууллагаар хянуулах хугацааг 10 хоногоор тогтоосон⁵⁷ нь цаг хугацааны хувьд практикт хэрэгжих боломжгүй тул 14 хоног болгохыг зөвлөсөн байтал энэ хугацааг өөрчлөлгүй, хэвээр өргөн барьсан, цаашилбал Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг батлахдаа 10 хоногийг нэмэх биш харин богиносгож гурав хоног⁵⁸ байхаар тогтоон батлан гаргажээ.

⁵⁴ Иж бүрэн авч үзсэн гэсэн баталгаа биш ч сонгон авсан зохицуулалт, шалгуур үзүүлэлтийн хувьд хангалттай гэж үзлээ.

⁵⁵ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 165 дахь тал.

⁵⁶ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 165 дахь тал.

⁵⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн 32.5, 32.6 дахь хэсэг.

⁵⁸ 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33.5, 33.6 дахь хэсэг.

УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжиж оролцож болох тухай зохицуулалтыг хассан боловч хориглоогүй байгаа нь мөн л практикт эргэлзээтэй байдал үүсгэхээр байна гэсэн зөвлөмж өгсөөр байтал өргөн барихдаа үүнийг нэмж тусгаагүй, батлагдсан хуульд ч хэвээр үлджээ.

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол”-ыг УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн төсвийн шинжилгээний алба хийж гүйцэтгэжээ. Тус тайланд “Дээрх хуулийн төсөл батлагдахад хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооллыг хийхдээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримталсан болно” гэсэн мэдэгдэл байгаа ч тус аргачлалын⁵⁹ зорилгыг ханган, аргачлалыг мөрдөж ажиллаагүй болох нь тайлангийн бүтэц, агуулгаас илэрхий харагдана.

“Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу хуулийн этгээд, иргэнд үүсэх зардлыг тооцоогүй, төрийн байгууллагын зардлыг л тооцсон байх бөгөөд зөвхөн сонгуулийн байгууллагаас сонгууль зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг авч үзжээ. Тус аргачлалын гол зорилго нь бүх зардлыг нарийвчлан тооцож, ачааллыг бууруулах санал боловсруулах ёстой ч тайланд зардлын ачааллыг багасгах санал, дүгнэлт бүхий хэсэг байхгүй байна.

2.4.3. Дүгнэлт, тайлбар

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 1.3 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино” гэжээ. Тус аргачлалын 2.2 дахь хэсэгт төслийн үр

⁵⁹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал.

нөлөөг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтэд “зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдал, зардал, харилцан уялдаа” зэрэг төрлийг жагсаасан байна. Хуулийн төслөөр хийгдсэн үр нөлөөний үнэлгээний тайланд “зардал” гэсэн шалгуураас бусад шалгуур үзүүлэлт бүрийг сонгон авч “ойлгомжтой байдал”, “харилцан уялдаа” гэсэн шалгуураар хуулийн төслийг бүхэлд нь, “зорилгод хүрэх байдал” шалгуураар есөн зүйлийн зарим заалт⁶⁰, “практикт хэрэгжих боломж” шалгуураар 30 дугаар зүйлийн 30.5-30.8 дахь хэсэг, “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуураар 79 дүгээр зүйлийн зарим хэсгийг⁶¹ сонгон, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоон, тохирох шалгах хэрэгслийг тодорхойлжээ.

“Хууль тогтоомж хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 1.2-т “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардлыг тооцож, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулахад энэхүү аргачлалын зорилго оршино” гэжээ. Тус хуулийн төслийн зардал тооцсон тайлангаас харахад зөвхөн төрийн байгууллагын зардал, тэр дундаа сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг л жагсаан оруулсан байхаас сонгогч буюу иргэн, хуулийн этгээдийн зардлыг тооцсон талаар мэдээлэл байхгүй байв. Ийнхүү зардал тооцох нь зөвхөн төсөв, тооцооны тухай асуудал бус харин аргачлалд⁶² дурдсан шиг “холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах” боломжтой эсэхийг тогтоох зорилготой. Тус тайлан нь холбогдох талуудын зардлын “ачааллыг аль болох багасгах санал боловсруулах” үндсэн зорилгын хүрээнд бус, зөвхөн сонгуулийн зарим үйл ажиллагааны төсвийг тооцон жагсаасан төдий болжээ.

⁶⁰ Төслийн 6, 3, 39, 40, 23, 14, 15, 16, 17 дугаар зүйлийн зарим заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, 10 дахь тал.

⁶¹ Мөн тэнд.

⁶² 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 2.7, 3.7, 4.7 дахь хэсэг.

2.5. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨЛӨӨЛӨЛ, ОЛОН НИЙТЭЭР ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЖ, САНАЛ АВАХ

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах⁶³ үе шатыг 18 шалгах асуултын дагуу үнэлэхэд таван асуултад “үгүй”, хоёр асуултад “тийм” гээд 11 асуултад албан ёсны мэдээлэл олдоогүй тул хариулаагүй. *Үнэлгээний ерөнхий дүн хоёр буюу “хангалтгүй”.*

2.5.1. Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага

38 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах

- 38.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.
- 38.2. Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн тайланг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана.
- 38.3. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 38.2-т заасан хугацаа 15-аас доошгүй хоног байна. Энэ хугацаанд иргэн, хуулийн этгээд саналаа бичгээр өгөх бөгөөд холбогдох этгээд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

⁶³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.5 дахь хэсэг.

- 38.4. Хууль санаачлагч энэ хуулийн 38.3-т заасны дагуу ирүүлсэн саналыг харгалзан үзнэ.
- 38.5. Олон нийтийн хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр явуулна:
- 38.5.1. бичгээр санал авах;
 - 38.5.2. уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
 - 38.5.3. санал асуулга явуулах;
 - 38.5.4. олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах;
 - 38.5.5. бусад хэлбэр.
- 38.6. Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулна.
- 38.7. Хууль санаачлагчийн боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн үндэсний аюулгүй байдлын үүднээс хуулиар нууцад хамааруулсан асуудалтай холбоотой хэсгээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй.
- 38.8. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 12.2-т заасан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно.

Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана⁶⁴.

Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооллын тайланг байршуулж⁶⁵, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заах бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол дээрх

⁶⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

⁶⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

хугацаа нь 15-аас доошгүй хоног⁶⁶ байна. Иргэн, хуулийн этгээд саналаа бичгээр өгөх бөгөөд холбогдох этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Хууль санаачлагч ирүүлсэн саналыг харгалзан үзэх бөгөөд олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулна.⁶⁷

Олон нийтийн хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр явуулна⁶⁸:

- Бичгээр санал авах;
- Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Санал асуулга явуулах;
- Олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах;
- Бусад хэлбэр.

Үндэсний аюулгүй байдлын үүднээс хэрэв хууль тогтоомжийн төсөлд хуулиар нууцад хамааруулсан асуудал байвал тэрхүү хэсгээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй⁶⁹. Харин Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт буюу олон улсын гэрээ соёрхон батлах тухай, тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотгол, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Засгийн газрын өрийн удирдлагын стратеги, улсын төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх, Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, УИХ-ын тухай болон УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай, онцгой албан татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх тухай УИХ-ын шийдвэрийн төсөл, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулахаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөл зэрэгт олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно.⁷⁰

⁶⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

⁶⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 6 дахь хэсэг.

⁶⁸ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.

⁶⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 7 дахь хэсэг.

⁷⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 8 дахь хэсэг.

2.5.2. Хуулийн шаардлага хангасан байдал

Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэгт албан ёсны мэдээлэл байхгүй байв.

Хуулийн төсөлд бичгээр санал авч байсан эсэхийг лавлаж үзэхэд Сонгуулийн ерөнхий хорооноос хуулийн төсөлд цахимаар санал авахдаа “Хуулийн төслүүдтэй танилцаад саналаа дэд ажлын хэсгийн ges.gov.mn цахим хаягаар болон Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр ирүүлэх боломжтой” гэсэн мэдээлэл цахим хуудсандаа байрлуулсан байв. Энэ талаар Сонгуулийн ерөнхий хорооноос лавлахад тухайн үед төрийн болон төрийн бус байгууллага, улс төрийн намууд саналаа албан бичгээр ирүүлж байсан бөгөөд энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны архивд хадгалагддаг байна. Олон нийтийн хэлэлцүүлгийг уулзалт, хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулсан эсэх талаар хуулийн хувийн хэрэгт албан ёсны мэдээлэл байгаагүй ч Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн ерөнхий хороо, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон УИХ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгтэй⁷¹ хамтран хуулиудын төслийн хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулсан⁷² талаар мэдээ нийтлэгдсэн байв. Тус хэлэлцүүлэгт сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагаанд үүрэг хүлээн оролцдог төрийн байгууллагууд, Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн 24 намын дарга, тэдгээрийн төлөөлөл, сонгуулийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, мониторинг хийж ажилладаг төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцжээ.

“Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас”-нд “Олон нийтийн хэлэлцүүлэг, сайтад байршуулсан мэдээлэл, саналын товьёг хавсаргасан”⁷³ гэсэн мэдээлэл

⁷¹ “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 195 тоот захирамж.

⁷² Монгол Улсын Сонгуулийн хороо (ges.gov.mn)

⁷³ УИХ-д өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 4 дэх тал.

байгаа ч хуулийн хувийн хэрэгт байгаагүй болно. Эндээс харахад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар холбогдох материалыг баримтжуулж, хуулийн төслийн бүрдүүлбэрт хавсаргасан байх хуулийн шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.5.3. Дүгнэлт, тайлбар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.1-д “хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана” гэжээ. Эндээс харахад уг ажлыг хариуцах эзэн нь хууль санаачлагч байх, цаг хугацааны хувьд өргөн мэдүүлэхээс өмнө буюу 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс өмнө байх, энэ үйл явцыг баримтжуулан бүрдүүлбэрт хавсаргахаар байна. Бодит байдал дээр холбогдох баримт бичгүүд нь хуулийн төслийн бүрдүүлбэрт хавсаргагдаагүй, хуулийн хувийн хэрэгт энэ талаар мэдээлэл байхгүй байв. Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан гэж байгаа ч гурван сонгуулийн асуудлыг нэгтгэн хуулийн хэлэлцүүлгийг нэг удаа хийснээр оролцоог хангасан гэж үзэх нь учир дутагдалтай юм. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг 2017-2019 онд бараг гурван жил ажиллах хугацаандаа ийнхүү нэг л удаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан нь хангалтгүй, нөгөө талаас олон нийтийн хэлэлцүүлгийн бусад хэлбэрийг ашиглан санал цуглуулах ажлыг хэрхэн зохион байгуулсан, цуглуулсан саналаа хуулийн төсөлд яаж тусгасан талаар албан ёсны мэдээлэл байхгүй байв. Иймд тус хуулийн төслийг олон нийтээр хүртээмжтэй хэлэлцүүлж, холбогдох талуудын саналыг хангалттай тусгасан байх хуулийн шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй гэж хэлэх үндэслэлтэй юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т заасны дагуу “албан ёсны цахим хуудас”-нд байршуулж санал авах, мөн хуулийн 38.5.4 дэх хэсэгт заасан “олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах” хоёр агуулга нь нэг эсвэл өөр, тусдаа ойлголт болох эсэх нь эргэлзээтэй. “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”⁷⁴-д “олон нийтийн

⁷⁴ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 3.2.4 дэх хэсэг.

цахим сүлжээгээр⁷⁵ хэлэлцүүлэг явуулах тохиолдолд хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн товч танилцуулгыг тавьж, дэлгэрүүлэн танилцах боломжтой цахим холбоосыг олон нийтэд мэдээлнэ” гэснээс харахад энэ хоёр зохицуулалт өөр байхаар байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2 дахь хэсэгт “Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, ...тайланг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана” гэж хариуцах эзнийг нь тодорхой заасан атал дэд ажлын хэсгийн хүрээнд буюу Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд байрлуулжээ. Сонгуулийн ерөнхий хороо хуулийн төсөл, үзэл баримтлалыг цахим хуудсандаа байршуулсан ч Хууль тогтоомжийн тухай хуульд тодорхойлсон тайлангууд, тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн төслийн хувьд үр нөлөөг нь үнэлсэн, зардлын тооцоо гаргасан тайлангуудыг байршуулаагүй байв. Нөгөө талаас, Сонгуулийн ерөнхий хороо нь “хууль санаачлагч” биш билээ. Эндээс дүгнэхэд хууль санаачлагчийн “албан ёсны цахим хуудас” гэдгийг хэрхэн ойлгох талаар Хууль тогтоомжийн тухай хуульд тодорхой зохицуулалт үгүйлэгдэж байна.

2.6. ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН БОЛОН СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ АВАХ

Хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах⁷⁶ үе шатыг таван шалгах асуултын дагуу үнэлэх ёстой байсан ч албан ёсны мэдээлэл олдоогүй тул хариулаагүй. *Үнэлгээний дүн нэг буюу “огт хангалтгүй”.*

⁷⁵ “Олон нийтийн цахим сүлжээ” гэдэгт тухайлбал, фэйсбүүк зэрэг платформыг ойлгодог нийтлэг хандлага бий.

⁷⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.6 дахь хэсэг.

2.6.1. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага

39 дүгээр зүйл. Төрийн байгууллагаас санал авах

- 39.1. Хууль санаачлагч санаачилж байгаа хууль тогтоомжийн төсөлдөө түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагаас санал авна.
- 39.2. Төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийн төсөлд харьяа болон холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг авч нэгтгэн хууль санаачлагчид хүргүүлж болно.
- 39.3. Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөлд тусгасан асуудал нь Улсын Их Хурлаас байгуулдаг төрийн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бол тухайн байгууллагаас санал авна.
- 39.4. Энэ хуулийн 39.1, 39.3-т заасан саналыг бичгээр үйлдэнэ.

2.6.2. Хуулийн шаардлага хангасан байдал

Тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон хэрэгжилтэд хяналт тавьж оролцдог төрийн байгууллагуудаас санал авч, тусгасан эсэхийг албан ёсны мэдээлэлд үндэслэн нягтлах боломжгүй байлаа. Харин үнэлгээний ажлын явцад хийсэн ярилцлага болон Төрийн байгуулалтын байнгын хороо, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн нэмэлт материалд 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Татварын ерөнхий газар, Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам зэрэг долоон байгууллагаас санал ирүүлсэн жагсаалт байгаа ч ирсэн саналуудыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар мэдээлэл олдоогүй болно.

Тухайн хууль тогтоомжоор зохицуулах асуудлаар ажилладаг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод зэргээс санал авсан эсэхийг мөн нягтлан шалгах боломжгүй байв. Үнэлгээний ажлын явцад хийсэн ярилцлага болон Төрийн байгуулалтын байнгын хороо, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн нэмэлт материалд Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам, Монголын ногоон нам, Монголын консерватив нам,

Монголын хүний төлөө нам, Хөдөлмөрийн үндэсний нам, Монгол ардын хувьсгалт нам, Монголын Үндэсний ардчилсан нам, Үнэн ба зөв нам санал ирүүлжээ. Тус баримтад төрийн бус хоёр байгууллагыг Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд⁷⁷ тусгайлан өгөх саналгүй гэсэн болохыг тэмдэглэлд тусгажээ. Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн “Хуулийн төсөлд ирүүлсэн санал” гэсэн жагсаалтад “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээ, “Хараат бус сонголт-Иргэний оролцоо”, “Сонгогчдын боловсрол төв” төрийн бус байгууллага, иргэн З.Батдорж нарын хуулийн төсөлд өгсөн саналыг жагсаан ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэсэн байх ч тухайн саналыг төсөлд тусгасан эсэх, ажлын хэсэг үүнийг хүлээн авсан эсэх талаар мэдээлэл байхгүй байв. “Ажлын хэсгээс 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр хуулиудын төсөлд санал авахаар улс төрийн 28 нам, төрийн 16 байгууллага, төрийн бус есөн байгууллагад урьдчилан хүргүүлсэн бөгөөд улс төрийн найман нам, төрийн найман байгууллага, төрийн бус хоёр байгууллагаас хуулийн төслүүдэд саналаа бичгээр ирүүлжээ”⁷⁸ гэсэн мэдээлэл байх ч үүнийг баталгаажуулах албан ёсны эх сурвалж олдоогүй болно.

2.6.3. Дүгнэлт, тайлбар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төсөлдөө түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагаас санал авах ёстой ч энэхүү хуулийн шаардлагыг хэрхэн хангаж байгааг үнэлэх мэдээлэл хуулийн хувийн хэрэгт байгаагүй. Харин холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх явцад Сонгуулийн ерөнхий хорооноос ажлын хэсэгт танилцуулахаар бэлдсэн жагсаалтыг олж авсан бөгөөд энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэгт байгаагүй тул эргэлзээтэй гэж үзээд үнэлгээ хийхэд ашиглах баталгаатай эх сурвалжид тооцоогүй болно. Нөгөө талаас, Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн хууль тогтоомж

⁷⁷ Тухайн үед Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулж санал авч байсан.

⁷⁸ Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (ges.gov.mn).

боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй⁷⁹ ч Хууль тогтоомжийн тухай хуулиар “хууль санаачлагч” биш тул тус байгууллагын санаачлан хийсэн ажлыг үнэлгээнд баримт болгон авч үзэхэд хүндрэлтэй юм. Мөн тус байгууллагын хийсэн холбогдох ажлын үр дүн хуулийн төслийн хувийн хэрэгт тусаагүй байх тул хамаатуулан үзэх боломжгүй болохыг давхар нотолно.

Энэ үе шатанд төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах ёстой ч хуулийн хувийн хэрэгт энэ төрлийн баримт, мэдээлэл алга байв. Тухайн үед “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн байгууллагууд ажлын хэсэгт саналаа хүргүүлсэн байдаг ч тэдгээр байгууллагын саналыг хуулийн хувийн хэрэгт хавсаргаагүй байв. Тухайлбал, Сонгогчдын боловсрол төвөөс 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр 01/19 тоот санал хүргүүлэх тухай албан бичиг (хавсралт дөрвөн хуудас, 12 тооны санал) хүргүүлж байсан ч хуулийн хувийн хэрэгт мөн хавсаргагдаагүй байлаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат”⁸⁰ хэсэгт “Хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах” үе шатыг тодорхойлсон ч тус хуулийн 39 дүгээр зүйлд зөвхөн “Төрийн байгууллагаас санал авах” гэсэн нэр бүхий нэг л зүйл дээрх үе шаттай холбоотой байна. Тиймээс “төрийн бус” бусад оролцогч талын саналыг хэрхэн, яаж авах талаар суурь зохицуулалт байхгүй байна гэж хэлж болохоор байна. Түүнчлэн энэ үе шат нь “хууль санаачлагч санаачилж буй хууль тогтоомжийн төсөл”⁸¹-дөө санал авах тухайд хамаарахаас Хууль тогтоомжийн тухай хуулийн долоодугаар бүлэгт байх “өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл”-д санал авах тухай зохицуулалт биш гэж ойлгогдож байна. Хуулийн хувийн хэрэгт байгаа баримтуудаас харахад төрийн найман

⁷⁹ 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангах дэд ажлын хэсэг” байгуулж, даргаар нь Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Ц.Болдсайханыг томилсон байна.

⁸⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл.

⁸¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 39.1 дэх хэсэг.

байгууллага⁸² (Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гадаад харилцааны яам, Үндэсний аудитын газар) санал ирүүлсэн байх бөгөөд эдгээр санал нь хуулийн төсөл өргөн мэдүүлсний дараа өгсөн санал байв. Эдгээр саналын зарим нь ажлын хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль батлагдсаны дараа очжээ.⁸³

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг эх барьсан зөвлөх Ц.Болормаагийн тайланд⁸⁴ “Ажлын хэсэг 11 дүгээр сарын 20-ноос 12 дугаар сарын 8-ны хооронд нийт таван удаа хуралдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн 50 орчим саналаас 40 орчмыг, УИХ-ын гишүүн А.Адъяасүрэнгийн 30 саналаас 20 орчмыг, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн 30 гаруй саналаас 20 орчмыг, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн⁸⁵ зургаан багц саналаас тавыг, Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн 25 саналаас 24-ийг, Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн таван саналаас гурвыг, Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн 11 саналаас тавыг, Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн таван саналаас гурвыг, Үндэсний аудитын газраас ирүүлсэн 14 саналаас наймыг төсөлд тусгах шаардлагатай гэж үзэн анхны хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй 71 санал, багц найруулгын гурван санал, эцсийн хэлэлцүүлгийн шатанд найман санал хэлэлцүүлж, хуульд тусгуулан баталсан” гэжээ. Эдгээр байгууллагатай зэрэгцээд төрийн бус байгууллагууд санал өгсөөр байтал авч хэлэлцээгүйгээс үзэхэд хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, сонгуулийн үйл явцад хуулиар тодорхой чиг үүрэг, эрх хэмжээтэй оролцдог нэг тал болох төрийн бус байгууллагын саналыг хууль тогтоомжийн төсөл хэлэлцэхдээ анхаарч үздэггүй хандлага ажиглагдлаа.

⁸² Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэргийн 68-116 дахь тал.

⁸³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 82 дахь тал.

⁸⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 191 дэх тал.

⁸⁵ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэгт Улсын бүртгэлийн байгууллагаас ирүүлсэн санал байгаагүй.

2.7. ТӨСЛИЙГ ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

Хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх⁸⁶ үе шатыг зургаан шалгах асуултын дагуу үнэлэхэд нэг асуултад “үгүй”, гурван асуултад “тийм” гээд хоёр асуултад албан ёсны мэдээлэл олдоогүй тул хариулаагүй. *Үнэлгээний ерөнхий дүн дөрөв буюу “ерөнхийдөө хангалттай”.*

2.7.1. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага

21 дүгээр зүйл. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газрын санал, дүгнэлтийг авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

- 21.1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлангийн хамт санал, дүгнэлт авахаар Засгийн газарт хүргүүлнэ.
- 21.2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгүүлэхээр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 21.3. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Засгийн газрын бусад гишүүн, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

⁸⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.8 дахь хэсэг.

- 21.4. Энэ хуулийн 21.3-т заасан байгууллага, албан тушаалтан нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд өгөх саналыг тухайн хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор бэлтгэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 21.5. Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд саналаа ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.
- 21.6. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын бусад гишүүнээс ирүүлсэн саналыг Засгийн газрын санал, дүгнэлтийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална:
- 21.6.1. зарчмын шинжтэй саналуудыг нэг бүрчлэн томьёолох;
- 21.6.2. хэл зүй, найруулга, томьёоллын шинжтэй саналуудыг багцлах.
- 21.7. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.4-т заасан хугацаа өнгөрсөн өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.
- 21.8. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг энэ хуулийн 21.7-д заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.
- 21.9. Энэ хуулийн 21.7-д заасан Засгийн газрын санал, дүгнэлтийн төсөлд дараах асуудлыг тусгана:
- 21.9.1. тухайн хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэж байгаа эсэх;
- ~~21.9.2. тухайн хууль тогтоомжийн төсөл бусад хууль тогтоомжтой уялдсан эсэх;~~
- 21.9.3. тухайн хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх.

- 21.10. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага, Төсвийн тухай хуульд заасан төсвийн бусад шаардлага, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хангаж байгаа эсэх талаарх Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгэж, энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.
- 21.11. Засгийн газар санал, дүгнэлтээ ажлын 30 өдрийн дотор хууль санаачлагчид хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хууль санаачлагчтай тохиролцон түүний бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн уг хугацааг сунгаж болно. Онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд 72 цагийн дотор саналаа хүргүүлнэ.
- 21.12. Засгийн газар энэ хуулийн 21.11-д заасан хугацаанд саналаа ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.
- 21.13. Засгийн газар энэ хуулийн 21.1-д заасан хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцээгүй, энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан тохиолдолд уг дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд заавал танилцуулна.
- 21.14. Улсын Их Хурлаас шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дотоод зохион байгуулалттай холбоотой хууль тогтоомжийн төсөлд Засгийн газраас санал авахгүй байж болно.

2.7.2. Хуулийн шаардлага хангасан байдал

Засгийн газрын санал, дүгнэлт авахаар хууль санаачлагч төслөө хүргүүлсний дагуу Засгийн газар 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ХЭГ/2102 тоот албан бичгээр 29 тоот тэмдэглэлийг хууль санаачлагчид хүргүүлсэн байна. Энэхүү санал дүгнэлтийг хууль санаачлагч 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авсан боловч хуулийн төслийг Засгийн газарт хэзээ хүргүүлсэн талаар мэдээлэл олдоогүй тул Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон хугацаанд⁸⁷ багтаан Засгийн газар холбогдох саналаа хүргүүлсэн эсэхийг нягтлах боломжгүй байв.

Хууль тогтоомжийн төсөл нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцсэн эсэх⁸⁸ талаарх Засгийн газрын дүгнэлт байгаагүй болно. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэлэлцсэн тэмдэглэлд “... хуулийн төслийг хэлэлцээд зарчмын хувьд дэмжиж...” гэсэн ерөнхий дүгнэлт байх бөгөөд тухайн хуулийн төсөлд холбогдуулан найман санал уламжилжээ. Эдгээр санал нь сонгогчдын санал авах үйл явцтай холбоотойгоос бус хууль тогтоомжийн төсөл нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцсэн эсэх талаарх аливаа дүгнэлт, мэдээлэл агуулаагүй байв.

Уг хууль тогтоомжийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд⁸⁹ заасан шаардлагыг хангасан эсэх талаарх Засгийн газрын дүгнэлт тодорхой бус байна. Тухайлбал, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 10 дахь хэсэгт “Төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн, хуулийн төсөл хоорондын давхардал, зөрчлийг арилгаж төслийн боловсруулалтыг сайжруулах нь зүйтэй” гэсэн ч ямар давхардал, зөрчил байгааг тодорхойлоогүй. Гэтэл тэмдэглэлээр өгсөн саналуудын дийлэнх нь хуулийн төсөлд нэмж оруулах санал байв.

⁸⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг.

⁸⁸ Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.9.1 дэх хэсэг.

⁸⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.9.3 дахь хэсэг.

2.7.3. Дүгнэлт, тайлбар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.9-д зааснаар Засгийн газрын санал, дүгнэлтэд тухайн хууль тогтоомжийн төсөл нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэж байгаа эсэх, тухайн хууль тогтоомжийн төсөл Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх асуудлыг тусгасан байх ёстой. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл байдлаар энэ санал, дүгнэлт гарсан хэдий ч Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцсэн эсэх талаарх дүгнэлт, мэдээлэл байхгүй, “Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн сайжруулах” гэсэн байгаа ч аль хэсэг нь зөрчигдсөн, нийцэхгүй байгаа талаар мөн нарийн, тодорхой асуудал тусгагдаагүй байна.

2.8. ТӨСЛИЙН БҮРДҮҮЛБЭРИЙГ ХАНГАЖ, УИХ-Д ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, УИХ-д өргөн мэдүүлэх⁹⁰ үе шатыг 14 шалгах асуултын дагуу үнэлэхэд гурван асуултад “үгүй”, 10 асуултад “тийм” гээд нэг асуултад албан ёсны мэдээлэл олдоогүй тул хариулаагүй. *Үнэлгээний ерөнхий дүн дөрөв буюу “ерөнхийдөө хангалттай”.*

2.8.1. Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага

40 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр

40.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд дараах баримт бичгийг хавсаргана:

40.1.1. хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх тухай хууль санаачлагчийн албан бичиг;

40.1.2. хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан;

⁹⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.9 дэх хэсэг.

- 40.1.3. дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл;
- 40.1.4. олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу хянан баталгаажуулсан олон улсын гэрээний монгол хэлээрх орчуулга;
- ~~40.1.5. хууль тогтоомжийн төсөл батлагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, авах арга хэмжээний санал;~~
- 40.1.6. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн тухайд Засгийн газрын санал, дүгнэлт;
- 40.1.7. Засгийн газрын өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн тухайд энэ хуулийн 20.7-20.9-д заасны дагуу санхүү, төсвийн, гадаад хэргийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бичгээр өгсөн зөвшөөрөл;
- 40.1.8. энэ хуулийн 15.2-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлсэн тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвлөмж;
- 40.1.9. энэ хуулийн 40.1.1-40.1.8-д заасан баримт бичгийн цахим хувь;
- 40.1.10. энэ хуулийн 38.6-д заасан саналын товъёг.
- 40.2. Энэ хуулийн 40.1-д заасан баримт бичиг нь албан хэрэг хөтлөлтийн нийтлэг шаардлагыг хангасан байна.
- 40.3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1-д заасан Хөтөлбөр болон Үндсэн чиглэлийн хэрэгжилт, мөн хуулийн 47.2-т заасан тайлан нь энэ хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна.
- 40.4. Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийн цахим хувийг үйлдэх, баталгаажуулах, хүлээлцэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

- 41.1. Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.
- 41.2. Хууль санаачлагч энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээс өмнө Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 41.3. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хууль тогтоомжийн төслийг 72 цагийн дотор энэ хуулийн 40.1, 40.2-т заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, шаардлага хангуулах арга хэмжээ авах, мөн хугацаанд шаардлага хангаагүй бол хууль санаачлагчид буцаана.
- 41.4. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга энэ хуулийн 40.1, 40.2-т заасан шаардлагыг хангасан төслийг Улсын Их Хурлын даргад танилцуулж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээр товлосон хугацааг хууль санаачлагчид албан бичгээр мэдэгдэнэ.

2.8.2. Хуулийн шаардлага хангасан байдал

Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт байвал зохих баримт бичгийн бүрдэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангасан эсэх тухай мэдээлэл

№	Байвал зохих баримт бичиг	тийм	үгүй
1	Хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэх тухай хууль санаачлагчийн албан бичиг байгаа эсэх	✓	
2	Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал байгаа эсэх	✓	

Хүснэгт 2-ын үргэлжлэл

3	Хууль тогтоомжийн төслийн танилцуулга байгаа эсэх	✓	
4	Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан байгаа эсэх		✓
5	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан байгаа эсэх	✓	
6	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан байгаа эсэх	✓	
7	Тухайн хуулийн төслийг дагалдан өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл байгаа эсэх	✓	
8	Засгийн газрын санал, дүгнэлт байгаа эсэх	✓	
9	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвлөмж байгаа эсэх	-	-
10	Дээрх баримт бичгийн цахим хувь байгаа эсэх	✓	
11	Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёг байгаа эсэх		✓

Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт байвал зохих баримт бичгүүдээс “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан”, “Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёг” гэсэн хоёр чухал баримт бичиг байгаагүй болно. “Олон нийтийн хэлэлцүүлэг, сайтад байршуулсан мэдээлэл, саналын товъёг хавсаргасан”⁹¹ гэсэн мэдээлэл байгаа ч хуулийн хувийн хэрэгт байгаагүй. Хэдийгээр Сонгуулийн

⁹¹ УИХ-д өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 4 дэх тал.

ерөнхий хорооноос хуулийн төсөлд санал авч байх үед оролцогч талуудаас ирсэн саналыг нэгтгэн, хуулийн төсөлд тусгасан эсэхийг үндэслэлийн хамт нэгтгэн, нийт 410 саналаас 339-ийг хүлээн авч, 71 санал аваагүй⁹² гэсэн мэдээлэл байгаа ч үүнийг албан ёсны гэж үзэх боломжгүй байв.

Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвлөмж байгаа тохиолдолд бүрдүүлбэрт хавсаргах ёстой ч хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлсэн эсэх⁹³ талаарх мэдээлэл олдоогүй. Гэсэн хэдий ч Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж болно⁹⁴ гэсэн заалт нь заавал байх шалгуур биш гэж үзлээ.

Хууль тогтоомжийн төслийг хуульд заасан шаардлагын дагуу УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Харин өргөн мэдүүлэхээр товлосон хугацааг хууль санаачлагчид албан бичгээр мэдэгдсэн байх⁹⁵ шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй болох нь “Товыг хууль санаачлагчид 266455 дугаарын утсаар 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдөр 15.00 цагт мэдэгдсэн”⁹⁶ гэсэн тэмдэглэлээс харагдаж байна.

2.8.3. Дүгнэлт, тайлбар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд “Хууль тогтоомжийн бүрдүүлбэр” буюу УИХ-д өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд хавсаргах баримт бичгийн жагсаалт байдаг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн бүрдүүлбэрээс “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан”, “Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёг” байхгүй байгаа нь

⁹² Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн “Хуулийн төсөлд ирүүлсэн санал” нэртэй Excel файлаас авав.

⁹³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.1.8 дахь хэсэг.

⁹⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.2 дахь хэсэг.

⁹⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.4 дэх хэсэг.

⁹⁶ УИХ-д өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 4 дэх тал.

анхаарал татаж байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн⁹⁷ зорилго болох “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, ...замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино” гэсэн үзэл баримтлалыг гажуудуулахад хүргэх талтай. Хуулийн төслийн бүрдүүлбэрийн ийм чухал баримт бичиг нь байхгүй атал Хууль тогтоомжийн тухай хуульд⁹⁸ заасны дагуу шаардлага хангасан эсэхийг хянаж, шаардлага хангуулах арга хэмжээ авалгүй “бүрдүүлбэр хангасан” гэж үзжээ.

⁹⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл.

⁹⁸ Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.2, 41.3 дахь хэсэг.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН

Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх “Шалгах хуудас”-ны 94 асуултын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх үйл явцыг шалгасан бөгөөд 26 асуултад “тийм”, 33 асуултад “хариулах боломжгүй”, 35 асуултад “үгүй” гэжээ. Үр дүнг Графикт харуулав.

График. Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, хувиар



Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үе шат бүрийн шалгах асуултад хариулсан байдлыг Хүснэгт 3-т харуулав.

*Хүснэгт 3. Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт
(үе шат болон шалгах асуултын тоогоор)*

Үе шат	Нэр	Шалгах асуултын тоо	Тийм	Үгүй	Хариулах боломжгүй
Нэгдүгээр үе шат	Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх	13 асуулт	-	2	11
Хоёрдугаар үе шат	Төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах	9 асуулт	1	8	-
Гуравдугаар үе шат	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	17 асуулт	3	12	2
Дөрөвдүгээр үе шат	Төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх	12 асуулт	7	4	1
Тавдугаар үе шат	Иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлж, санал авах	18 асуулт	2	5	11
Зургаадугаар үе шат	Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах	5 асуулт	-	-	5
Долоодугаар үе шат	Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	6 асуулт	3	1	2

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Наймдугаар үе шат	Төслийн бүрдүүлбэрийг хангаж, УИХ-д өргөн мэдүүлэх	14 асуулт	10	3	1
Нийт хариултын тоо			26	35	33

Үнэлгээний судалгааны үр дүнд үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн дүнг гаргахад “2.3” буюу “хангалтгүй” гэсэн дүн гарав (Хүснэгт 4-ийг дэлгэрүүлэн харна уу).

*Хүснэгт 4. Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг
үнэлсэн үнэлгээний нэгдсэн дүн*

№	Хэсэг	Нэр	Үнэлгээ				
			1	2	3	4	5
1	Нэг	Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх	+				
2	Хоёр	Төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах	+				
3	Гурав	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах		+			
4	Дөрөв	Төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх			+		
5	Тав	Иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлж, санал авах		+			

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

6	Зургаа	Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах	+
7	Долоо	Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	+
8	Найм	Төслийн бүрдүүлбэрийг хангаж, УИХ-д өргөн мэдүүлэх	+
9	Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн нэгдсэн (дундаж) үнэлгээ:	2.3 буюу “хангалтгүй”	

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ⁹⁹

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат”-нд хамаарах 17 орчим зүйлийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор “Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх шалгах хуудас” бэлтгэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх үйл явцыг сонгон авч, тус шалгах хуудсаар үнэлэн, дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон шаардлага, зохицуулалтыг 94 шалгах асуултад багтаан үнэлэхэд 28 хувь нь “тийм” (26 асуулт), 35 хувь нь “хариулах боломжгүй” (33 асуулт), 37 хувь нь “үгүй” (35 асуулт) гэсэн дүн гарлаа. “Хариулах боломжгүй” гэсэн нь хууль санаачлагч тухайн хуулийн төслийг боловсруулахдаа эдгээр шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй гэсэн үг биш бөгөөд харин тухайн үйл явц, үе шатанд холбогдох албан ёсны, бодитой эх сурвалж олдоогүй, үнэлэхэд шаардлагатай мэдээлэл хангалтгүй байгаатай холбоотой. Нөгөө талаас энэ асуудал нь хууль тогтоох үйл явц нээлттэй, ил тод байх хуулиар тогтоосон шаардлагыг хангаагүй болохыг илтгэн харуулж байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан холбогдох аргачлалаар тогтоосон 94 шаардлагын 68-ыг хангаагүй нь тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг

⁹⁹ Энэхүү үнэлгээний судалгааны нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг зөвхөн энэ судалгааны хүрээнд авч үзсэн болохыг онцолж байна.

харуулж байна. Үүнийг УИХ-ын дарга Г.Занданшатарын хэлсэн дараах үг¹⁰⁰ мөн баталж байна:

- “Энэ хуулийг¹⁰¹ 2017 онд УИХ-аар батлан мөрдүүлж эхэлсэн цагаас хойш хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлага тодорхой болж, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх замаар нэмэлт өөрчлөлт хийх, төсөл боловсруулах шатанд олон нийтийн оролцоог хангах, судалгаа шинжилгээ, баримт нотолгоонд тулгуурлан хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг шаардлагуудыг тодорхой болгосон. Гэвч хэрэгжилт хангалтгүй байгааг иргэдийн зүгээс байнга хэлсээр байна”¹⁰².
- Сонгон авсан хуулийн төслийн хувьд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”, “Төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах”, “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах” гэсэн үндсэн гурван үе шат огт хангалтгүй, түүнчлэн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах”, “Иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлж, санал авах” үе шат хангалттай мөрдөгдөөгүй байна. Ийнхүү хуулийн төсөл боловсруулах ажлын дараалал алдагдаж байгаа нь хуулийн төслийн чанар, үр нөлөөнд сөргөөр нөлөөлөхөд хүргэжээ.
- Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгдэх хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил огт хийгдээгүй байна. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөө, хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо зэргийг

¹⁰⁰ 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр УИХ-ын Тамгын газар Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах нь” сэдэвт цахим уулзалт, хэлэлцүүлгийн үеэр хэлсэн үг.

¹⁰¹ Хууль тогтоомжийн тухай хуулийг хэлж байна.

¹⁰² <https://ikon.mn/n/2dtl?fbclid=IwAR3C9NGQ6pqN2P4cD-7J-gcZ7H60lf3FRxxYz-hlNHGM8XsLG6sRNdq3Ng0>

Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох аргачлалын дагуу иж бүрэн, чанартай, хангалттай хийгээгүй болох нь үнэлгээний үр дүнгээс харагдаж байна. Энэ нь тухайн хуулийн төсөл боловсруулах ажиллагааны үндэслэл, хэрэгцээ шаардлага тодорхой бус болоход нөлөөлөн, цаашлаад хуулийн төсөл боловсруулах ажлын үр дүнг сулруулж, хуулийн зохицуулалтын чанар, үр нөлөөг бууруулах эрсдэлтэй харагдаж байна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат бүрд холбогдох дүгнэлтийг нэгтгэн, товчилж харуулбал:

- 1) Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлал хамаарахгүй байх гурван тохиолдлыг нэрлэснээс 12.3.1 нь “...тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан”¹⁰³ гэх зохицуулалт байна. Харин үүнийг ямар шалгуур баримтлан тогтоох нь эргэлзээтэй байна.
- 2) Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш таван жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэжээ. Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явц, журмыг зохицуулж байсан Сонгуулийн тухай хууль батлагдан, хэрэгжээд таван жил болсон байтал Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна.
- 3) Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.2-т заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”¹⁰⁴-ын дагуу үнэлж, тухайн хууль тогтоомжийн “хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийн, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа

¹⁰³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1 дэх хэсэг.

¹⁰⁴ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт.

ээрэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх” боломжийг тодорхойлж байж хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулах зэргээр дараагийн үе шатны ажиллагаа хийгдэх ёстой байтал суурь судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байна. Үүнээс улбаалан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг үзэл баримтлалд тусгахдаа Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын¹⁰⁵ 3.2.2, 3.2.3, 3.2.4, 3.2.5-д заасны дагуу бус, хэт ерөнхий, тоймлох байдалтай байна.

- 4) Үзэл баримтлалын “Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц” хэсэг нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахгүй, хэтэрхий ерөнхий, зарим хэсэг нь хоорондоо зөрчилтэй байдлаар томъёологджээ. Түүнчлэн үзэл баримтлалын эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулахдаа авч үзэх ёстой шаардлагууд, тайлбарлаж оруулах мэдээлэл, мөн “хуулийн төслийг баталж хэрэгжүүлснээр гарах үр дүнг тусгайлан заана”¹⁰⁶, “хүрэх үр дүнг заахдаа хэт ерөнхий байдлаар бичихээс зайлсхийх” гэснийг анхаарч үзээгүй, хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- 5) Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдаж байгааг тодорхойлох, эрх зүйн тогтолцоонд тухайн хуулийн эзлэх байр суурь, ямар хуулийн салбарт хамаарах, хуулийн төсөл батлагдан гарснаар тухайн салбарын хууль тогтоомжид гарах үр нөлөө, ач холбогдлыг тусгах зэрэг Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд¹⁰⁷ байгаа шаардлагыг хангаагүй байна. Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох

¹⁰⁵ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

¹⁰⁶ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.4.6 дахь хэсэг.

¹⁰⁷ Дээрх аргачлалын 1 дүгээр бүлгийн 3.5 дахь хэсэг.

тухай хуулийн талаар “Ямар хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, ямар хуулийг хүчингүй болсонд тооцох шаардлагатай байгааг судалж, хуулийг нэрээр нь тодорхой заана”¹⁰⁸ гэсэн байгаа ч Сонгуулийн тухай хуулиас өөр ямар ч хуулийг нэрлэн заагаагүй байв.

- 6) Хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль санаачлагчдын нэг нь баталсан байтал хуулийн хувийн хэрэгт байгаа материалуудаас харахад уг хуулийн төслийг нэг бус, хэд хэдэн гишүүн хамтран санаачилсан байна. Энэ тохиолдолд хуулийн төслийн үзэл баримтлалыг хэрхэн батлах талаар нарийвчилсан зохицуулалт Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох аргачлалд тусаагүй.
- 7) Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд¹⁰⁹ зааснаар “танилцуулга нь хуулийн төслийн үзэл баримтлалын тухай биш харин хуулийн төслийн тухай” байх, “танилцуулгыг боловсруулахдаа үзэл баримтлалыг хуулбарлан давхардуулж бичихгүй” байх зэрэг шаардлагыг хангаагүй. Хуулийн төслийн танилцуулгад тусгах ёстой мэдээллээс “тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал” гэсэн хэсгээс бусад нь тусгагдаагүй, танилцуулгын бичвэрийн ерөнхий бүтэц, стандартыг холбогдох аргачлалд нэг бүрчлэн тодорхойлсон байтал огт баримтлалгүй боловсруулсан байв. Тухайлбал, төслийн үзэл баримтлалын “Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага” гэсэн нийт таван параграфыг танилцуулгад үг, үсгийн зөрүүгүй шууд хуулбарлан тавьсан, үлдэх хоёр параграф нь “Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц” хэсгээс мөн хуулбарлан авсан буюу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулгын бараг 99 хувь нь хуулийн төслийн үзэл баримтлалтай яг давхацжээ.

¹⁰⁸ Дээрх аргачлалын 3.5.3 дахь хэсэг.

¹⁰⁹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 7.4 дэх хэсэг.

- 8) Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 1.2-т “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардлыг тооцож, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулахад энэхүү аргачлалын зорилго оршино” гэсэн атал зөвхөн төрийн байгууллагын зардал, тэр дундаа сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг л жагсаан оруулсан бөгөөд харин сонгогч буюу иргэн, хуулийн этгээдийн зардлыг тооцсон талаар мэдээлэл байхгүй байна. Ийнхүү зардал тооцох нь зөвхөн төсөв, тооцооны тухай асуудал бус харин аргачлалд¹¹⁰ дурдсан шиг “холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах” боломжтой эсэхийг тогтоох зорилготой юм.
- 9) Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т заасны дагуу “албан ёсны цахим хуудсанд байршуулж санал авах”, мөн хуулийн 38.5.4 дэх хэсэгт заасан “олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах” хоёр агуулга нь нэг эсвэл тусдаа, өөр өөр ойлголт болох эсэх нь эргэлзээтэй. Хууль санаачлагчийн “албан ёсны цахим хуудас” гэдгийг хэрхэн ойлгох талаар Хууль тогтоомжийн тухай хуульд тодорхой зохицуулалт байхгүй байна¹¹¹.
- 10) Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах үе шатанд төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах ёстой ч хуулийн хувийн хэрэгт энэ төрлийн баримт, мэдээлэл алга. Тухайн үед “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн байгууллагууд, Сонгогчдын боловсрол төв санал хүргүүлсэн ч хуулийн хувийн хэрэгт байхгүй байв.

¹¹⁰ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт,” Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 2.7, 3.7, 4.7 дахь хэсэг.

¹¹¹ Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх шатанд иргэд, олон нийтийн оролцоог хангах үүднээс хуулийн төсөл боловсруулах lawmaker.parliament.mn, хуулийн төсөлд иргэдийн санал авах lawforum.parliament.mn цахим платформ бий болгосон байна.

- 11) Хууль тогтоомжийн тухай хуулиар “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат”¹¹² хэсэгт “хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах” үе шатыг тодорхойлсон ч тус хуулийн 39 дүгээр зүйлд зөвхөн “Төрийн байгууллагаас санал авах” гэсэн нэг л зүйл энэ үе шаттай холбоотой байна. Тиймээс “төрийн бус” бусад оролцогч талын саналыг хэрхэн, яаж авах талаар суурь зохицуулалт байхгүй гэж хэлж болохоор байна. Дээр дурдсан шиг төрийн бус байгууллагууд санал өгсөөр байтал авч хэлэлцээгүй нь хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, сонгуулийн үйл явцад хуулиар тодорхой чиг үүрэг, эрх хэмжээтэй оролцдог нэг тал болох төрийн бус байгууллагын саналыг хууль тогтоомжийн төсөл хэлэлцэхдээ анхаарч үздэггүй болохыг батлан харуулж байна.
- 12) Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана” гэжээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн бүрдүүлбэрээс “Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товьёг” байхгүй байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹¹³ зорилго болох “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, ...замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино” гэх үзэл баримтлалыг гажуудуулах талтай. Хуулийн төслийн бүрдүүлбэрийн ийм чухал баримт бичиг нь байхгүй атал Хууль тогтоомжийн тухай хуульд¹¹⁴ заасны дагуу шаардлага хангасан эсэхийг хянаж, шаардлага хангуулах арга хэмжээ авалгүй, “бүрдүүлбэр хангасан” гэж үзжээ.

¹¹² Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл.

¹¹³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл.

¹¹⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.2, 41.3 дахь хэсэг.

Эдгээр дүгнэлтэд үндэслэн дор дурдсан санал, зөвлөмж гаргаж байна. Үүнд:

- Хууль тогтоомжийн тухай хууль хэрэгжиж эхлээд таван жил өнгөрсөн¹¹⁵ тул тус хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”-г Хууль тогтоомжийн тухай хуульд оруулах, цаашид хэрэгжилтийг сайжруулах эсвэл зохицуулалтыг нь боловсронгуй болгох зэргээр шаардлагатай шинэчлэлийг өргөн хүрээтэй авч үзэх;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, түүнд хяналт тавих үйл явц, журмыг УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль гарах гэж буйтай холбогдуулан анхаарч тусгах, тухайлбал, хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр хангаагүй, төсөл боловсруулах үе шат бүрд байх шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд өргөн мэдүүлдэггүй байх;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг тогтмол болгох, тухайлбал, энэхүү үнэлгээний судалгааны суурь аргачлал болсон “Шалгах хуудас” ашиглан УИХ-аар хэлэлцэх гэж буй хууль тогтоомжийн төслийг үнэлэх, хянах иргэд, иргэний нийгмийн байгууллагын санаачилгыг дэмжих, олон нийтийн хяналт бий болгох;
- Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох аргачлалыг хэрхэн ойлгож, ашиглах, хуулийн төсөл боловсруулах ажлын арга зүй, техник зэрэгтэй холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг хууль санаачлах эрх бүхий этгээдүүд болон төрийн бус байгууллага, олон нийтийн дунд зохион байгуулах.

¹¹⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3-г зааснаар тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш таван жил тутамд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 2020.
4. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2019.
5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, 2020.
6. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2005.
7. Сонгуулийн тухай хууль, 2015.
8. Монгол Улсын Засгийн газрын “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоол, 2016.

Хоёр. Хуулийн төсөлд холбогдох баримт бичиг

1. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль”-ийн хувийн хэрэг, 1-4 дүгээр боть, 2020.
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, 2019.
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, 2019.
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 2019.
5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулга (хуулийн хувийн хэрэг, 3-р боть, 105-106 дахь тал.), 2020.
6. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, 2020.
7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, 2019.

8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол хийсэн тайлан.
9. “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 195 тоот захирамж.
10. 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” хууль санаачлагчийн баталсан баримт бичиг.
11. 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн төлөвлөгөө”.
12. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн санал, дүгнэлт.
13. “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 04 дугаартай тогтоол.
14. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн санал, дүгнэлт.
15. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн танилцуулга.
16. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн эх барьсан зөвлөх Ц.Болормаагийн тайлан, 2020.
17. Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн 12 хуудас бүхий санал, төрийн долоон байгууллага, улс төрийн найман нам, төрийн бус хоёр байгууллага (2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар буюу хуулийг өргөн барихаас өмнө).

18. Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн 6 хуудас бүхий санал.
19. Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн “Хуулийн төсөлд санал авч байна” гэсэн гарчигтай цахим хуудасны нүүр зураг.

Гурав. Хуралдааны тэмдэглэл

1. “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх хугацааг товлох” тухай хууль санаачлагчийн 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 12856 тоот албан бичиг.
2. “Төслийн бүрдүүлбэр хянуулах” тухай хууль санаачлагчийн 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 12923 тоот албан бичиг.
3. Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл.
4. УИХ-ын чуулганы 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.
5. УИХ-ын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.
6. УИХ-ын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.

Дөрөв. Албан бичиг

1. “Хүсэлт гаргах тухай” Сонгогчдын боловсрол төвийн 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 48 тоот албан бичиг.
2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2102 тоот албан бичиг.
3. Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн ТГ-05/1017 дугаартай албан бичиг.
4. Сонгуулийн ерөнхий хорооны 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 111 тоот албан бичиг.
5. “Санал хүргүүлэх тухай” Сонгогчдын боловсрол төвийн 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 01/19 тоот албан бичиг.
6. Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайханд 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдөр судлаачаас хүргүүлсэн албан захидал.

7. Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн ТГ-02/801 дугаартай албан бичиг.
8. Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайханд 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр судлаачаас хүргүүлсэн албан захидал.

Тав. Цахим хуудас

<http://forum.parliament.mn>

www.parliament.mn

www.gec.gov.mn

<https://ikon.mn/n/2dtl?fbclid=IwAR3C9NGQ6pqN2P4cD-7J-gcZ7H60lf3FRxxYz-hlNHGM8XsLG6sRNdq3Ng0>

ХАВСРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ

ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

- Үнэлгээний энэ хуудсыг Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд ашиглана.
 - Үнэлгээний шалгах асуултуудыг Хууль тогтоомжийн тухай хууль болон тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д үндэслэн боловсруулсан.
 - Энэхүү үнэлгээний хуудасны шалгах асуултуудыг ашиглан Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат бүрийг хэсэгчлэн болон хууль тогтоомжийн төслийн онцлогт тохируулан хялбаршуулан үнэлэх боломжтой.
 - Тус үнэлгээний хуудсыг зөвхөн хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатыг үнэлэхэд зориулан боловсруулсан бөгөөд хуулийн төслийн бүтэц, хэлбэр, эх бичвэрт тавих шаардлагыг хамааруулаагүй болно.
-

-
- Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний боловсруулж, өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн хувьд уг үнэлгээний хуудсыг ашиглах боломжтой бөгөөд Засгийн газраас боловсруулж, өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн тухайд зарим үе шат нь ялгаатай байдаг тул энэхүү үнэлгээний хуудсыг ашиглах тохиолдолд шалгах асуултуудыг өөрчлөх боломжтой.
 - Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд зориулсан энэхүү үнэлгээний хуудас нь тухайн хуулийн төслийн ерөнхий танилцуулга, хэлэлцэж баталсан хугацаа, үйл явцын болон үнэлгээ хийх багийн мэдээлэл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах үндсэн найман үе шат, Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь үнэлэх хэсгээс бүрдэнэ.
-

ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС БӨГЛӨХ ЗААВАРЧИЛГА

- Тухайн хууль тогтоомжийн төслөөр зохицуулах салбарын өргөн мэдлэг, мэдээлэлтэй, энэ чиглэлээр мэргэшин ажиллаж буй хувь хүн эсхүл баг энэхүү үнэлгээний хуудсыг ашиглан үнэлгээ хийвэл илүү дөхөмтэй.
 - Шалгах асуултын дагуу үнэлгээ хийхийн өмнө тухайн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх үйл явцтай холбоотой бүхий л мэдээллийг олж цуглуулсан байх шаардлагатай.
 - Эдгээр мэдээллийг дараах арга замаар олж авах боломжтой. Үүнд:
 - Хууль тогтоомжийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг олж авах (цахим хувилбараар <http://forum.parliament.mn>-ээс авах);
 - Хууль тогтоомжийн хувийн хэрэгтэй биечлэн танилцах, хуулбарлан авах (УИХ-ын Тамгын газар);
-

-
- УИХ, холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, баталсан тухай хуралдааны тэмдэглэл, Байнгын хорооны дүгнэлт, ажлын хэсэг байгуулсан тогтоол, харилцсан албан бичиг, холбогдох тайлан, судалгаа (parliament.mn-ээс авах);
 - Хуулийн төсөл санаачлагч, хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдтэй уулзалт зохион байгуулах, ярилцлага хийх;
 - Бусад эх сурвалж.
- Үнэлгээний шалгах асуулт бүрд хариулахдаа баримт, нотолгоонд суурилахыг чармайна. Тоо баримт, дүгнэлт, холбогдох талуудын санал, тайлан, уулзалт болон хуралдааны тэмдэглэл, танилцуулга зэрэг холбогдох бүхий л мэдээллийг цуглуулахдаа мэдээллийн эх сурвалжийн баталгаатай, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг харгалзан үзэж, бодитой байхад анхаарна.
 - Үнэлгээний хуудасны шалгах асуултыг бөглөхдөө “Тийм”, “Үгүй” гэсэн аль ч хувилбарыг сонгосон “Тайлбар, үндэслэл” хэсэгт үндэслэл, шалтгаан, нотлох баримт болон боломжтой тохиолдолд эх сурвалж зэргийг товч, тодорхой бичнэ. Энэ нь үнэлгээний хуудасны ес дэх хэсгийг бөглөхөд суурь мэдээлэл болох юм. Мөн тухайн асуултад “Тийм”, “Үгүй” гэсэн байдлаар хариулах боломжгүй тохиолдолд тухайн асуултын “тайлбар, үндэслэл” хэсэгт үндэслэл, шалтгаанаа сайтар тайлбарлаарай.
 - Хэсэг тус бүрийн төгсгөлд “Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар” хэсэг байх бөгөөд тухайн хэсгийн үнэлгээний үр дүнг нэгтгэн оруулж, үнэлгээ хийж буй судлаач үнэлгээгээ дэлгэрүүлэн тайлбарлаж, дүгнэлт, төсөөлөл, таамаглал зэргийг дэвшүүлэн, дүн шинжилгээ хийсэн мэдээллээ оруулах боломжтой. Түүнчлэн үнэлгээний үр дүнд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгаан, уялдаа холбоо зэргийг дурдаж болно.
-

- Ес буюу үнэлгээний төгсгөлийн хэсгийг бөглөхдөө шалгах асуултын дагуу таван оноогоор үнэлнэ. 5-хангалттай сайн, 4-ерөнхийдөө хангалттай, 3-дундаж, 2-хангалтгүй, 1-огт хангалтгүй гэсэн байдлаар тохирох оноог дугуйлан Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээг дундажлан тооцож гаргана.

ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА, МЭДЭЭЛЭЛ

1. Хуулийн төслийн ерөнхий танилцуулга

№	Асуулт	Хариулт
1	Хуулийн төслийн нэр	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
2	Хуулийн төслийн зорилго	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлон, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад ¹¹⁶ оршино.
3	Хуулийн төслийн зохицуулах гол харилцаа	Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, сонгууль зохион байгуулах журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбоотой харилцаа
4	Хуулийн төсөл санаачлагчийн нэр	– УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан – УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар нар
5	Хуулийн төслийн үзэл баримтлалыг баталсан этгээдийн нэр	УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан

¹¹⁶ “хангахад” гэсэн үг өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд байгаагүй.

Үргэлжлэл

6	Хуулийн төсөл өргөн мэдүүлэхээр товлосон хугацаа	2019 оны 12 дугаар сарын 2, 12856 тоот “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх хугацааг товлдох тухай” албан бичиг
7	Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн огноо	2019 оны 12 дугаар сарын 3, 12923 тоот “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай” албан бичиг
8	Хуулийн төсөл өргөн мэдүүлсэн этгээд	УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан
9	Байнгын хороогоор хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг хэлэлцсэн огноо	2020 оны 1 дүгээр сарын 08 Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн.
10	Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг хэлэлцсэн огноо	2020 оны 1 дүгээр сарын 09 Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.
11	Байнгын хорооны хурлаар төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн огноо	2020 оны 12 дугаар сарын 10 Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, зарчмын зөрүүтэй 70 саналыг хуралдаанд оролцсон олонх дэмжсэн.

12	Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн огноо	2020 оны 12 дугаар сарын 11 УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.
13	Байнгын хорооны хурлаар төслийн эцсийн хэлэлцүүлэг хийсэн огноо	2020 оны 12 дугаар сарын 16 11 цаг 37 минутад эхэлж, 12 цаг 03 минут хүртэл эцсийн хэлэлцүүлэг хийгдсэн байна.
14	Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн эцсийн хэлэлцүүлэг хийсэн огноо	2020 оны 12 дугаар сарын 17 Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг сонсож, зарчмын зөрүүтэй таван саналаар санал хураалт явуулж, эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн байна.
15	Хуулийн төсөл батлагдсан огноо	2020 оны 12 дугаар сарын 24 https://www.legalinfo.mn/law/details/15826?lawid=15826
16	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн нэр	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Н.Энхболд Гишүүд: – УИХ-ын гишүүн А.Адъяасүрэн – УИХ-ын гишүүн С.Бямбацогт – УИХ-ын гишүүн Х.Нямбаатар – УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн

Нарийн бичгийн дарга:

Ц.Болормаа – Хууль, эрх зүйн газрын
зөвлөх

Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 04 дугаартай тогтоолоор байгуулсан байна. Энэ ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахад санал өгөх, шаардлагатай саналын томьёолол боловсруулах үүрэг бүхий ажлын дэд хэсгийг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Сонгуулийн ерөнхий хороо, Цагдаагийн Ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Гадаад хэргийн яам зэрэг долоон байгууллагаас төлөөлөл оролцуулан байгуулсан байна.¹¹⁷

17	Хуулийн төслийн төрөл ¹¹⁸	✓ Анхдагч хуулийн төсөл
		– Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл
		– Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
		– Багц хуулийн төсөл
		– Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

¹¹⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулга.

¹¹⁸ Хууль тогтоомжийн тухай хуулийн 22.1 дэх заалт.

2. Үнэлгээ хийсэн судлаач

№	Асуулт	Хариулт
1	Судлаачийн товч танилцуулга	Сумъяагийн Оюунтуяа Сонгогчдын боловсрол төвийн гүйцэтгэх захирлаар ажилладаг, сонгуулийн эрх зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийж ирсэн туршлагатай. Эрх зүйч мэргэжилтэй, төрийн удирдлагын магистр, нийтийн удирдлагаар докторантурт суралцаж буй.
2	Үнэлгээ эхэлсэн огноо	2021 оны 9 дүгээр сарын 20
3	Үнэлгээ дууссан огноо	2021 оны 10 дугаар сарын 20

3. Үнэлгээ хийхэд ашигласан эх сурвалж

Жагсаалт

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль;
- Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Сонгуулийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоол.

Хуулийн төсөлд холбогдох баримт бичиг:

- “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль”-ийн хувийн хэрэг, 1-4 дүгээр боть;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга;

-
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулга (хуулийн хувийн хэрэг, 3-р боть, 105-106 дахь тал.);
 - Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол хийсэн тайлан;
 - “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 195 тоот захирамж;
 - “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” хууль санаачлагчийн 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр баталсан баримт бичиг;
 - 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн төлөвлөгөө”;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн санал, дүгнэлт;
 - “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 04 дугаартай тогтоол;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн санал, дүгнэлт;
-

-
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн танилцуулга;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн эх барьсан зөвлөх Ц.Болормаагийн тайлан;
 - Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн 12 хуудас бүхий санал, төрийн долоон байгууллага, улс төрийн найман нам, төрийн бус хоёр байгууллага (2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар буюу хуулийн төсөл өргөн барихаас өмнө);
 - Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал, зургаан хуудас материал;
 - Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн “Хуулийн төсөлд санал авч байна” гэсэн гарчигтай цахим хуудасны нүүр зураг.

Хуралдааны тэмдэглэл:

- “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх хугацааг товлох” тухай хууль санаачлагчийн 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 12856 тоот албан бичиг;
 - “Төслийн бүрдүүлбэр хянуулах” тухай хууль санаачлагчийн 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 12923 тоот албан бичиг;
 - Засгийн газрын хуралдааны 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 29 дүгээр тэмдэглэл;
 - Чуулганы нэгдсэн хуралдааны 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн тэмдэглэл;
 - Чуулганы нэгдсэн хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн тэмдэглэл;
 - Чуулганы нэгдсэн хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн тэмдэглэл.
-

Албан бичиг:

- Сонгогчдын боловсрол төвийн 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн “Хүсэлт гаргах тухай” 48 тоот албан бичиг;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2102 тоот албан бичиг;
- Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн ТГ-05/1017 дугаартай албан бичиг;
- Сонгуулийн ерөнхий хорооны 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 111 тоот албан бичиг;
- Сонгогчдын боловсрол төвийн 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн “Санал хүргүүлэх тухай” 01/19 тоот албан бичиг;
- Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайханд 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдөр судлаачаас хүргүүлсэн албан захидал;
- Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн ТГ-02/801 дугаартай албан бичиг;
- Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайханд 2021 оны 9 дугаар сарын 17-ны өдөр судлаачаас хүргүүлсэн албан захидал;

Цахим хуудас:

- <http://forum.parliament.mn>
 - www.parliament.mn
 - www.gec.gov.mn
-

НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ,
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

1.1. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан эсэх¹¹⁹

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан тайлан бий эсэх	✓		Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1-д заасны дагуу “тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд ¹²⁰ заасан” тул хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал хамаарахааргүй байна. Эх сурвалж: - УИХ-д өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах ханалтын хуудас. ¹²¹

¹¹⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл.

¹²⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн 30, 31 дүгээр зүйл.

¹²¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэг, 4 дэх тал.

Үргэлжлэл

2	Тайланг “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлал” -ын дагуу судалж, зөвлөмж гаргасан эсэх	-
3	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцсэн эсэх	-
4	Тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлсон эсэх	-
5	Тухайн асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлсон эсэх	-
6	Зохицуулах эрх зүйн хэм хэмжээний эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсан эсэх	-
7	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлсон эсэх	-
8	Тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа хийсэн эсэх (шаардлагатай тохиолдолд)	-

1.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн эсэх¹²²

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан бий эсэх	✓		“Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас” ¹²³ -нд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан “+” буюу “байгаа” гэсэн тэмдэглэлтэй байх ч холбогдох хуулийн хувийн хэрэгтэй биечлэн танилцахад тус тайлан байгаагүй. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайланг ирүүлэх хүсэлт бичгээр гарган 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн боловч хуулбарлан ирүүлсэн баримт бичигт тус тайлан байгаагүй тул хийгдээгүй байна гэж үзлээ.
2	Тайланг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн эсэх		-	

¹²² Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл.

¹²³ “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль”-ийн хувийн хэрэг, 4 дэх тал.

Үргэлжлэл	
3	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг багатах асуудлыг хамруулсан эсэх - Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэг, боть 4; - 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ТГ-05/1017 дугаартай УИХ-ын Тамгын газрын албан бичиг.
4	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийн, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлсон эсэх -
5	Зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлсон эсэх -

Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар

Хэсэг 1.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх

Дүгнэлт, тайлбар:

- Тухайн хуулийн төслийн зохицуулах харицааг хуулиар зохицуулахаар тусгайлан Үндсэн хуульд заасан тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах шаардлагагүй байна гэж үзжээ. Гэхдээ “тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан”¹²⁴ гэдгийг ямар шалгуур баримтлан тогтоох нь эргэлзээтэй байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 21.4-т “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг **хуулиар тогтооно**”, 59.3-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг **хуулиар тогтооно**” гэж тухайлан заасан байна. Үндсэн хуулийн 30 болон 31 дүгээр зүйлд ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, нэр дэвшүүлэх эрх, сонгуулийн үе шат, сонгууль хүчинтэй байх тохиолдол, дахин санал хураалт болон дахин сонгууль явуулах үндэслэл зэргийг дурдсан байх ч тухайлан Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1 болон дээр дурдсан бусад сонгуулийн адил “...тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан” тодорхой заалт Үндсэн хуулийн холбогдох хэсэгт алга байна.

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш таван жил тутамд хийх бөгөөд шаардлагагүй тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэжээ. Үндсэн хууль 1992 онд батлагдсанаас хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 1993 онд баталсан Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулиар таван удаа,

¹²⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1 дэх хэсэг.

Үргэлжлэл

2012 онд багтагдсан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар нэг удаа, харин 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 2015 онд багтагдсан Сонгуулийн тухай хуулиар зохион байгуулсан. Эндээс харахад Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явц, журмыг зохицуулж байсан Сонгуулийн тухай хууль батлагдаж, хэрэгжээд таван жил болсон байна. Тиймээс Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хуулийн шаардлага хангагдаагүй байна гэж үзэх үндэслэл байна. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “Эдгээр сонгуулийг нэгдсэн нэг хуулиар”¹²⁵ зохион байгуулж явуулахад учирсан хууль хэрэглээний болоод зохион байгуулалтын хүндрэлтэй нөхцөл байдал нь сонгуулийн онцлог харилцааг тусгайлан зохицуулсан, зөвхөн тухайн сонгуульд үүсэж буй харилцааг зохицуулах хуулийн зохицуулалт, тусгайлан хууль шаардлагатай болохыг харуулж байна” гэжээ. Өөрөөр хэлбэл, “хууль хэрэглээний” болон “зохион байгуулалтын хүндрэлтэй нөхцөл” байдал гэдгийг тогтоохдоо Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.2-т заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”¹²⁶-ын дагуу үнэлж, тухайн хууль тогтоомжийн “Хэрэгжилтийн явц дахь ололтыг багатах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх” боломжийг тодорхойлох ёстой. Ингэснээр Сонгуулийн тухай хууль нь Ерөнхийлөгчийг сонгохтой холбоотой харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хуулийн зорилго, зорилтоо хангаж чадсан эсэх, чадахгүй байгаа тохиолдолд шалтгааныг тодорхойлох, нийгэмд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг тодорхойлон, засварлаж сайжруулах, практикт гарсан хүндрэл нь юу болох, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалт байсан бол түүнийг хэрхэн зохицуулах боломжтой хувилбарыг тогтоож, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн чанарыг сайжруулахад ашиглах боломжтой юм.

¹²⁵ 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр багтагдсан Сонгуулийн тухай хуулийг хэлж байна.

¹²⁶ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт.

ХОЁР. ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, БАТЛАХ¹²⁷

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Үзэл баримтлалын төслийг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр боловсруулсан эсэх	✓		Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлаагүй ¹²⁸ , мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй ¹²⁹ талаар өмнөх хэсэгт авч үзсэн. Тиймээс үзэл баримтлал нь хуульд заасан шаардлагын хүрээнд боловсруулагдаагүй байх үндэслэлтэй. Мөн хуулийн төслийн үзэл баримтлалыг хэзээ баталсан нь мэдэгдэхгүй буюу огноо тавиагүй байна. Эх сурвалж: - УИХ-д өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах ханалтын хуудас ¹³⁰ ; - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэг, боть 4; - Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ТГ-05/1017 дугаартай албан бичиг.

¹²⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 14, 15 дугаар зүйл.

¹²⁸ Тус үнэлгээний 2.1-ийг харна уу.

¹²⁹ Тус үнэлгээний 2.2-ыг харна уу.

¹³⁰ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэг, 4 дэх тал.

Үргэлжлэл

2	Үзэл баримтлалд хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл шаардлагыг “тодорхой тайлбарлаж” тусгасан эсэх	✓	Төсөл боловсруулах болсон үндэслэл шаардлагыг үзэл баримтлалд хангалттай, “тодорхой тайлбарлаж” ¹³¹ тусгаагүй гэж үзлээ. “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал” ¹³² -ын 3.2-т заасны дагуу үндэслэл, шаардлагыг заахдаа харгалзан үзэж, дурдаж болох дөрвөн төрлийн асуудлыг тодорхой авч үзээгүй, хэтэрхий ерөнхий байдлаар тодорхойлсон байна. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 10-12 дахь тал.
3	Үзэл баримтлалд хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тусгасан эсэх	✓	Үзэл баримтлалд хууль тогтоомжийн зорилгыг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг төсөөлөн төлөвлөөгүй ¹³³ , ерөнхий бүтцийн хувьд Хууль тогтоомжийн тухай хууль ¹³⁴ , “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал” ¹³⁵ -д дурдсан наад захын “урьдчилан төсөөлж болох хамгийн ерөнхий бүтцийг

¹³¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.3 дахь хэсэг.

¹³² 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

¹³³ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3.7 дахь хэсэг.

¹³⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.1 дэх хэсэг.

¹³⁵ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3 дахь хэсэг.

Үргэлжлэл

гаргах” шаардлага хангаагүй, зохицуулах харилцаа, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлоогүй, хэтэрхий ерөнхий, бүрхэг байдлаар тусгасан байна гэж үзлээ.

Эх сурвалж:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 10-12 дахь тал.

4	Үзэл баримтлалд хууль тогтоомж багтагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар тусгасан эсэх	✓	Энэ хэсгийг үзэл баримтлалд тусгахдаа хэтэрхий ерөнхий, ажил хэрэгч бус, дутуу буюу иж бүрэн, тодорхой тайлбарлаж тусгаагүй, холбогдох аргачлалын дагуу цогцоор нь авч үзээгүй ¹³⁶ байна. Эдийн засгийн үр дагавар, нийгмийн үр дагавар, хууль зүйн үр дагавар, эдгээртэй холбоотой авч хэрэгжүүлэх санал зэргийг бүхэлд нь нэг өгүүлдэрт багтаан томъёолжээ. Тухайн хууль тогтоомжийн төслийг баглан хэрэгжүүлснээр гарах зардлын тооцоог холбогдох аргачлалын дагуу хийсэн байтал энэ талаар тоо, мэдээллийг тусгаагүй байна.
---	--	---	--

¹³⁶ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.4 дэх хэсэг.

Үргэлжлэл

Эх сурвалж:		Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 10-12 дахь тал.	
5	✓ Үзэл баримтлалд хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах талаар санал тусгасан эсэх	✓	Үзэл баримтлалд энэ хэсэг огт байхгүй, орхигдсон гэж хэлж болохоор байна. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна” гэснээс өөр мэдээлэл байхгүй. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 10-12 дахь тал.
6	✓ Үзэл баримтлалд хууль хэрэгжүүлэхэд шаардлагатай шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хууль тогтоомжийн талаар тусгасан эсэх	✓	Үзэл баримтлалд энэ талаар тодорхой тусгаагүй зөвхөн “..Сонгуулийн тухай хуулийн Ерөнхийлөгчийн сонгуулийн харилцааг зохицуулж байсан бүлэг бүхэлдээ хүчингүй болно. Холбогдох хуулийн төслүүдийг хамтад нь боловсруулна” гэснээс өөр мэдээлэл байхгүй.

Үргэлжлэл

Эх сурвалж:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 10-12 дахь тал.

✓

7 Хуулийн төслийн үзэл баримтлалыг эрх бүхий этгээд баталсан эсэх

Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.1-д “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн өөрийн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж батална” гэж заасан. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 2.2 дахь хэсэгт заасан холбогдох шаардлагын дагуу байна.

Эх сурвалж:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 10-12 дахь тал;
- Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн ТГ-02/801 дугаартай албан бичиг.

Үргэлжлэл

8	Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлсэн эсэх	✓	Үнэлгээний хүрээнд цуглуулсан болон олж авсан мэдээллийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, зөвлөмж авсан тухай мэдээлэл олдоогүй. Гэхдээ энэ зохицуулалт ¹³⁷ нь заавал байх шаардлага биш буюу “хүргүүлж болох” - оор, хүргүүлсэн тохиолдолд “зөвлөмж” ирүүлэхээр байна.
9	Тийм бол хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн зөвлөмж гаргасан эсэх	✓	

¹³⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.2 дахь хэсэг.

Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар

Хэсэг 2.

Төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах

Дүгнэлт, тайлбар:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна” гэсэн хуулийн заалт хэрэгжээгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”¹³⁸-ын 3.2.1-д зааснаар үнэлгээ хийсэн хуулийн төслийн тухайд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, энэ үнэлгээний үр дүнд үндэслэн үзэл баримтлал боловсруулах ёстой байжээ.
- Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг үзэл баримтлалд тусгахдаа “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”¹³⁹-ын 3.2.2, 3.2.3, 3.2.4, 3.2.5-д заасны дагуу тухайн хууль батлах хэрэгцээ, шаардлага байгааг нотолсон эрдэмтэн, судлаачдын хийсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон холбогдох байгууллагуудаас гаргасан санал, дүгнэлтийг харгалзан үзэж тусгах, хууль тогтоох чиглэлээр төрийн дээд байгууллагаас гаргасан бодлогын баримт бичгийг дурдах, Монгол Улсын олон улсын гэрээний хэм хэмжээнд нийцүүлэх шаардлага гарсныг заах эсвэл хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийснээр тухайн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага байгааг тодорхойлсон санал зөвлөмжийг үндэслэл болгох боломжтой. “Төслийн үзэл баримтлал” хэсэгт үндэслэл, шаардлагыг “... сонгуулиудыг нэгдсэн нэг хуулиар зохион байгуулж явуулахад учирсан хууль хэрэглээний болоод зохион байгуулалтын хүндрэлтэй нөхцөл байдал нь сонгуулийн онцлог харилцааг тусгайлан зохицуулсан, зөвхөн тухайн сонгуульд үүсэж буй харилцааг зохицуулах хуулийн зохицуулалт, тусгайлан хууль шаардлагагай болохыг харуулж байна.

¹³⁸ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

¹³⁹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

Үргэлжлэл

Иймээс Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах ерөнхий шаардлага зэргийг харгалзан Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох тусгайлсан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, түүнчлэн Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах зэргээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох шаардлага үүсэж байна” гэж тодорхойлсон нь аргачлалд дурдсан шиг биш хэг ерөнхий, тоймлох байдалтай байна.

– Үзэл баримтлалын “Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц” хэсэг нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахгүй, хэтэрхий ерөнхий, зарим хэсэг нь хоорондоо зөрчилтэй байдлаар томъёологдсон байна. Үзэл баримтлалын “Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага” хэсэгт Сонгуулийн тухай хууль буюу бүх сонгуулийг нэгдсэн нэг хуулиар зохион байгуулж байгаа нь хүндрэл үүсгэж байгаа тул “тусгайлсан хууль шаардлагатай” гэж хэрэгцээг тодорхойлсон боловч “Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц” гэсэн хоёр дахь хэсэгт “..Сонгуулийн тухай хуулийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой харилцааг зохицуулсан суурь зохицуулалтуудад үндэслэн, түүний үзэл баримтлалын хүрээнд боловсруулна” гэсэн нь агуулгын хувьд зөрчилтэй харагдаж байна.

– Үзэл баримтлалын гурав дахь хэсэгт эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар “Энэхүү хуулийн төсөл багтагдсанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулах эрх зүйн орчин боловсронгуй болж, хууль хэрэглээний болоод зохион байгуулалтын хувьд нэг мөр, ойлгомжтой болохоос гадна хууль хоорондын уялдаа хангагдаж хэрэгжилтийг нэг мөр хангах нөхцөл бүрдэнэ” гэж нэг өгүүлбэрт багтаан тодорхойлжээ.

Үргэлжлэл

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 3.4-т энэ хэсгийг боловсруулахдаа авч үзэх ёстой шаардлага, тайлбарлаж оруулах мэдээллийг заасан, мөн “хуулийн төслийг баталж хэрэгжүүлснээр гарах үр дүнг тусгайлан заана”¹⁴⁰ гээд “хүрэх үр дүнг заахдаа хэт ерөнхий байдлаар бичихээс зайлсхийх” гэснийг анхаарч үзээгүй, хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдаж байгааг тодорхойлох, эрх зүйн тогтолцоонд тухайн хуулийн эзлэх байр суурь, ямар хуулийн салбарт хамаарах, хуулийн төсөл батлагдан гарснаар тухайн салбарын хууль тогтоомжид гарах үр нөлөө, ач холбогдлыг тусгах зэрэг “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”¹⁴¹-д заасан шаардлагыг хангаагүй байна. Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаар “ямар хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, ямар хуулийг хүчингүй болсонд тооцох шаардлагатай байгааг судалж, хуулийг нэрээр нь тодорхой заана”¹⁴² гэсэн байгаа ч Сонгуулийн тухай хуулиас өөр ямар ч хуулийг нэрлэн заагаагүй.
- Хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль санаачлагчдын нэг болох УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан баталсан байна. Хуулийн хувийн хэрэгт байгаа материалууд болон төслийн үзэл баримтлалын гурав дахь нүүрний төгсгөл хэсэгт “Хууль санаачлагчид” гэж бичсэн зэргээс харахад уг хуулийн төслийн бас нэг санаачлагч нь УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар байна. Хуулийн төслийн үзэл баримтлалыг хэд хэдэн гишүүн хамтран боловсруулахад хэрхэн батлах талаар нарийвчилсан зохицуулалт Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох аргачлалд байхгүй байна.

¹⁴⁰ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3.4.6 дахь хэсэг.

¹⁴¹ Дээрх аргачлалын 1 дүгээр бүлгийн 3.5 дахь хэсэг.

¹⁴² Дээрх аргачлалын 3.5.3 дахь хэсэг.

ГУРАВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

3.1. Хуулийн төслийн танилцуулгад дараах мэдээлэл туссан эсэх¹⁴³

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Танилцуулга нь үзэл баримтлалыг хуулбарлаж, давхардуулахгүй байх шаардлага хангаж буй эсэх	✓		Танилцуулгын бараг 99 хувь буюу нийт найман параграфын долоо нь хуулийн төслийн үзэл баримтлалтай яг давхцаж байна.
Эх сурвалж:				
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 10-12 дахь тал;				
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 13-14 дэх тал.				

¹⁴³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйл.

Үргэлжлэл

2	Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтын талаар мэдээлэл бий эсэх	✓	Хуулийн төслийн танилцуулга нь үзэл баримтлалаа хуулбарлан хийгдсэн тул тухайн төсөлтэй холбоотой эдгээр мэдээллийг хангалттай, дэлгэрэнгүй өгөхгүй байна гэж үзлээ. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 13-14 дэх тал.
3	Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн талаар мэдээлэл бий эсэх	✓	Байна. Нийт найман параграфын гурав нь тухайн асуудлыг зохицуулж ирсэн хууль тогтоомжийн талаар дурджээ. Гэхдээ энэ хэсэг нь төслийн үзэл баримтлалаас хуулбарлан оруулсан мэдээлэл байна. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 13-14 дэх тал.

Үргэлжлэл	
4	Хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл бий эсэх ✓ Холбогдох мэдээлэл огт байхгүй. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр богийн 13-14 дэх тал.
5	Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүнгийн талаар мэдээлэл бий эсэх ✓ Холбогдох мэдээлэл огт байхгүй. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр богийн 13-14 дэх тал.
6	Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлтийн талаар мэдээлэл бий эсэх ✓ Холбогдох мэдээлэл огт байхгүй. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр богийн 13-14 дэх тал.

Үргэлжлэл

7	Танилцуулгын үг, хэллэгийг өнгөрсөн цаг дээр бичсэн эсэх	✓	Танилцуулгын үг, хэллэг өнгөрсөн цаг дээр бичигдсэн байна. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр богийн 13-14 дэх тал.
8	Төслийн танилцуулгын бичвэрийн бүтцийн стандартад тавих шаардлага хангагдсан эсэх	✓	Хуулийн төслийн танилцуулгын эхний хуудсанд “ТАНИЛЦУУЛГА” гэсэн үгийг танилцуулгын бичвэрийн дээд талд том үсгээр голлуулан бичих, дараагийн мөрний зүүн доод өнцөгт хуулийн нэрийг тухайлан бичиж, танилцуулгын төгсгөлд хууль санаачлагчийн нэрийг тавих ¹⁴⁴ шаардлага хангаагүй байна. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр богийн 13-14 дэх хуудас.

¹⁴⁴ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 7.5 дахь хэсэг.

3.2. Хуулийн төслийн агуулга нь хуульд заасан дараах шаардлагыг хангаж буй эсэх¹⁴⁵

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хуулийн төслийн “Хуулийн зорилго”-д хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгасан эсэх	✓		Тийм. Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй ¹⁴⁶ . Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.
2	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан эсэх	✓		Үгүй. Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж, ойлгомжгүй байдал үүсгэж буй, төслийн зохих хэсэгт тусгаагүй зүйл, заалт хэд хэд байна ¹⁴⁷ , “Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль

¹⁴⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

¹⁴⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 33 дахь тал.

¹⁴⁷ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 49 дэх тал.

Үргэлжлэл

тогтоомжтой уялдаагүй заалт хэд хэд байна”¹⁴⁸ гэжээ. Тухайлбал, төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “арван найм, дөчин таван нас хүрсэн” гэсэн нэр томъёог тодорхойлон тусгасан хэдий ч нэр дэвшигчийн тухайд энэ тодорхойлолт нь Монгол Улсын Үндсэн хууль болон хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт тусгасан зохицуулалттай зөрчилдөхөөр байна, мөн төслийн 57 дугаар зүйлийн 57.1-д сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07.00-20.00 цагт авахаар, төслийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт гадаад улсад байгаа сонгогчийн саналыг санал авах өдөр тухайн орон нутгийн цагаар 07.00-22.00 цагт авахаар тусгасан нь мөн хуулийн тэгш байдлын зарчмыг алдагдуулж, иргэдэд ялгавартай хандсан зохицуулалт болсон гэж үзэж болохоор¹⁴⁹ байна.

Түүнчлэн Ерөнхийлөгчид бие даан нэр дэвших эрхийг хуулиар зөвшөөрдөггүй, парламентад суудалгүй улс төрийн намууд оролцох боломжгүй байгаа зэрэг нь Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактаар хүлээсэн үүрэг, хэм хэмжээтэй зөрчилдөж байна¹⁵⁰.

¹⁴⁸ Мөн тэнд, 50 дахь тал.

¹⁴⁹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 50 дахь тал.

¹⁵⁰ Тус Пактын 25 дугаар зүйлийн тухай НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан 25 дугаар Ерөнхий тайлбарын 15 дахь хэсэгт

Үргэлжлэл

Эх сурвалж:		
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.		
3	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан эсэх	✓ Үгүй. Хуулийн төсөлд сонгуулийн анхан шатны санал хураалтын үед сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан боловч хоёр дахь санал хураалт явуулах тохиолдолд сонгуулийн сурталчилгааг хэрхэн явуулах талаар зохицуулалт тусгаагүй ¹⁵¹ .
Эх сурвалж:		
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.		

“Сонгогдох эрх эдлэх боломжгүй хүмүүсээс бусад хүн боловсрол, оршин суугаа газар, гарал үүсэл эсвэл улс төрийн харьяаллын шалтгаан гэх мэт үндэслэлээр ялгаварлан гадурхахдаа ёсгүй” хэмээн заасан байдаг.

¹⁵¹ Энэ талаар 2017 оны Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хорооны сүүлийн тайлангийн 14 дэх талд “Сонгуулийн тухай хуулиар зөвхөн сонгуулийн анхан шатны санал хураалтын үед сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Харин сонгуулийн хоёр дахь санал хураалтын үеэрх сонгуулийн сурталчилгааны тухайд хуулийн хийдэл байгаа нь ажиглагдав” гэжээ.

Үргэлжлэл

4	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрэнээс хальсан асуудлыг тусгахгүй байх шаардлагыг хангаж буй эсэх	✓	Тийм. Хуулийн төсөлд зохицуулах харилцаа, хүрэнээс хальсан зүйл тусгасан нь судалгаагаар тогтоогдоогүй ¹⁵² . Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.
5	Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт хооронд зөрчилгүй байх шаардлагыг хангаж буй эсэх	✓	Үгүй. Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдөж болзошгүй хэд хэдэн тохиолдол илэрсэн ¹⁵³ гэжээ. Тухайлбал, төслийн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцээгүй ¹⁵⁴ , нэр томъёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томъёотой нийцэхгүй ¹⁵⁵ , төсөлд тусгагдсан зарим зүйл, заалт нь хуулийн төслийн болон бусад хуультай нийцээгүй ¹⁵⁶ талаар мэдээлэл байна.

¹⁵² Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 32 дахь тал.

¹⁵³ Мөн тэнд, 32 дахь тал.

¹⁵⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 50 дахь тал.

¹⁵⁵ Мөн тэнд, 50 дахь тал.

¹⁵⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 51 дэх тал.

		Үргэлжлэл	
		Эх сурвалж:	
		- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 117-172 дахь тал.	
6	Хуулийн төсөлд хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх шаардлагыг хангаж буй эсэх	✓	Тийм. Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй ¹⁵⁷ .
		Эх сурвалж:	
		- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 117-172 дахь тал.	

¹⁵⁷ Мөн тэнд, 32 дахь тал.

3.3. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ерөнхий шаардлагыг хангаж буй эсэх¹⁵⁸

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль тогтоомжийн төсөл нь үзэл баримтлалын хүрээнд байгаа эсэх	-	-	Үнэлэх боломжгүй байна. Энэхүү үнэлгээний гурав дахь хэсгийн “Төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, багтах” хэсэгт “үзэл баримтлал нь хуульд заасан шаардлагын хүрээнд боловсруулагдаагүй”, “төсөл боловсруулах үндэслэл шаардлагыг хангалттай, тодорхой тайлбарлаж тусгаагүй”, “үзэл баримтлалд хууль тогтоомжийн зорилгыг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг төсөөлөн төлөвлөөгүй”, “урьдчилан төсөөлж болох хамгийн ерөнхий бүтцийг гаргах” зэрэг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан наад захын шаардлагыг хангахгүй байна гэж үзсэн болно.

¹⁵⁸ Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйл.

Үргэлжлэл

2	Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулсан эсэх	✓	Үгүй. Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төсөл боловсруулаагүй байна¹⁵⁹. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.
3	Холбогдох тооцоо, судалгаа хийсэн эсэх	-	Үнэлэх боломжгүй байна. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” болон “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол” хийгдсэн байна. Гэхдээ “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан”-г “Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас”¹⁶⁰-нд “+” буюу “байгаа” гэсэн тэмдэглэлтэй байх ч холбогдох хувийн хэрэгтэй биечлэн танилцахад тус тайлан байгаагүй.

¹⁵⁹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 2019 он, 33 дахь тал.

¹⁶⁰ “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль” -ийн хувийн хэрэг, 4 дэх тал.

Үргэлжлэл

Түүнчлэн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан тайлан байхгүй, Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1-д заасны дагуу “Тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд¹⁶¹ заасан” гэсэн үндэслэлээр авч үзээгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Эх сурвалж:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 117-172 дахь тал;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 173-190 дэх тал.

¹⁶¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 30, 31 дүгээр зүйл.

Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар

Хэсэг 3.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

Дүгнэлт, тайлбар:

- “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”¹⁶²-д зааснаар “танилцуулга нь хуулийн төслийн үзэл баримтлалын тухай биш харин хуулийн төслийн тухай” байх, “танилцуулгыг боловсруулахдаа үзэл баримтлалыг хуулбарлан давхардуулж бичихгүй” байх зэрэг шаардлагыг хангаагүй байна. Төслийн үзэл баримтлалын “Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага” гэсэн нийт таван параграфыг танилцуулгад шууд үг, үсгийн зөрүүгүй хуулбарлан тавьсан, үлдэх хоёр параграфыг “Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц” гэсэн хэсгээс мөн хуулбарлан авсан байна. Танилцуулгад төслийн үзэл баримтлалаас ялгаатай ганц л өгүүлбэр байгаа нь “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл нь 11 бүлэг, 81 зүйлтэй бөгөөд төслийн үзэл баримтлалд заасан үндэслэл, шаардлагын дагуу боловсруулаа” гэсэн байна. Танилцуулга нь хуулийн төсөл боловсруулсны дараа бичигддэг, гэтэл танилцуулгад төсөлд тусгасан зарчмын шинэлэг зохицуулалтыг¹⁶³ “дэлгэрэнгүй тайлбарлах”¹⁶⁴ хууль тогтоомжийн шаардлагууд ийнхүү хангагдаагүй байна.
- Хуулийн төслийн танилцуулгад тусгах ёстой мэдээллээс “тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал” гэсэн хэсгээс бусад нь тусгагдаагүй, танилцуулгын бичвэрийн ерөнхий бүтэц, стандартыг холбогдох аргачлалд нэг бүрчлэн тодорхойлсон байтал огт баримтлаагүй байна.

¹⁶² 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 7.4 дэх хэсэг.

¹⁶³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэг.

¹⁶⁴ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 7.3 дахь хэсэг

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, ЗАРДЛЫН ТООЦООГ ХИЙХ

4.1. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн эсэх¹⁶⁵

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан байгаа эсэх	✓		Тийм. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ”-г 2019 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс гүйцэтгэсэн байна. Судалгааны захиалагч нь хууль санаачлагч, УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан байжээ.
Эх сурвалж:				
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.				

¹⁶⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл.

Үргэлжлэл

2	“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлж, зөвлөмж гаргасан эсэх	✓	Тийм. Тус тайлан нь “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” ¹⁶⁶ -ын 1.4 дэх хэсэгт заасан үе шат, 2.2 дахь хэсэгт заасан үр нөлөөг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтийн төрөл тус бүрийг ¹⁶⁷ багтаасан, 5.1 дэх хэсэгт заасны дагуу үр нөлөөг үнэлсэн үр дүнг баримтжуулж, үнэлэх, зөвлөмжийг багтаасан ¹⁶⁸ байна. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.
3	Хууль тогтоомжийн төсөл эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож, шинжилсэн эсэх	✓	Тийм. Сонгон авсан асуудлаар практикт хэрэгжих боломж, харилцан уялдааг тооцож авч үзсэн байна ¹⁶⁹ . Тухайлбал, Төрийн аудитын дээд байгууллагаас нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргахаар

¹⁶⁶ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

¹⁶⁷ “2.2.5. зардал” гэсэн хэсгийг эс тооцвол. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол”-ыг тусад нь хийсэн байгааг энэ хэсгийн 5.2-оос харах боломжтой.

¹⁶⁸ Энд үр нөлөөг үнэлсэн тайлангийн чанарын асуудлыг хөндөөгүй болохыг тусгайлан тэмдэглэж байна.

¹⁶⁹ Иж бүрэн авч үзсэн гэсэн баталгаа биш ч сонгон авсан зохицуулалт, шалгуур үзүүлэлтийн хувьд хангалттай гэж үзлээ.

Үргэлжлэл

олгосон хугацаа нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг авч үзээд нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хуульд нийцээгүй тохиолдолд алдааг засуулан дахин дүгнэлт гаргах, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх зэрэгт 10 хоног олгосон нь¹⁷⁰ олон улсын стандартын дагуу аудит хийх боломжит хугацаатай нийцэхгүй байгаа талаар дурджээ.

Эх сурвалж:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.

4	Хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчил арилгах асуудлыг багтаасан эсэх	✓	Тийм. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ”-ний тайланд “Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд хэд хэдэн зөрчилтэй заалт илэрсэн ¹⁷¹ . Үүнд, Төрийн албаны тухай хуульд
---	---	---	---

¹⁷⁰ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 165 дахь тал.

¹⁷¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 167 дахь тал.

Үргэлжлэл

“Гурван жилийн хугацаанд төрийн албанд эргэж орох эрхгүйгээр халах” зохицуулалтыг “Нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах” гэж өөрөөр зохицуулсан, мөн төсөлд торгуулийн арга хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон нэмэгдүүлж авахаар тусгасан нь Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуультай нийцэхгүй байна”¹⁷² гэжээ.

Эх сурвалж:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.

Тийм.	✓	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” - ний тайланд тухайлбал, “Өмнөх сонгуулийн хууль тогтоомжид байсан Улсын Их Хуралд суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжиж оролцож болох тухай зохицуулалтыг хассан боловч хориглоогүй байгаа нь практикт эргэлзээтэй байдал үүсгэхээр
-------	---	---

5	Хууль тогтоомжийн төслийг баглан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоолоогүй үр дагаврыг тодорхойлсон эсэх	✓
---	---	---

¹⁷² Мөн тэнд.

Үргэлжлэл

байна. Сонгуулийн хороод нь хамтын удирдлагагай бөгөөд эрх хэмжээнийхээ асуудлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон хуралдаанаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэдэг тул бүрэлдэхүүний тоог тодорхой байдлаар, сондгой тоогоор тогтоох нь зүйн хэрэг юм. Гэтэл төслийн зохицуулалтад “5-7” гэснээр бүрэлдэхүүний тоо “6” ч байж болохоор ойлгогдож байна”¹⁷³ гэжээ.

Эх сурвалж:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.

6	Тайлангийн үр дүнд үндэслэн тухайн хууль тогтоомжийн төсөл, түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулах ажил хийгдсэн эсэх (шаардлагагай бол)	-	-	Үнэлгээ хийхэд 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдөр http://forum.parliament.mn сайтад “Baatarchuluun Zolboo” гэсэн хаягаас нийтлэгдсэн хуулийн төсөл ¹⁷⁴ олж авсан тул энэ асуултад хариулах боломжгүй байв. Гэхдээ энэ хэсгийн гурав болон тав дахь асуултад хариулахдаа сонгон авсан хоёр зохицуулалтыг
---	---	---	---	---

¹⁷³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 165 дахь тал.

¹⁷⁴ <http://forum.parliament.mn/projects/10744>

Үргэлжлэл

жишээ болгон авч үзэв. Хуулийн төсөлд нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө төрийн аудитын байгууллагаар хянуулах хугацааг 10 хоногоор тогтоосон¹⁷⁵ нь цаг хугацааны хувьд практикт хэрэгжих боломжгүй тул 14 хоног болгохыг зөвлөсөн байтал энэ хугацааг хэвээр нь өргөн барьсан, цаашилбал Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг батлахдаа 10 хоногийг нэмэх биш харин богиносгож гурав хоног¹⁷⁶ байхаар тогтоожээ. “УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжиж оролцож болох тухай зохицуулалтыг хассан боловч хориглоогүй байгаа нь практикт эргэлзээтэй байдал үүсгэхээр байна” гэсэн зөвлөмж өгсөөр байтал өргөн барихдаа үүнийг нэмж тусгаагүй, батлагдсан хуульд ч орхигдсон хэвээр байна.

Эх сурвалж:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.

¹⁷⁵ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн 32.5, 32.6 дахь хэсэг.

¹⁷⁶ 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33.5, 33.6 дахь хэсэг.

4.2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн эсэх¹⁷⁷

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан байгаа эсэх	✓		Тийм. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол”-ыг УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн төсвийн шинжилгээний алба хийж гүйцэтгэсэн байна.
Эх сурвалж:				
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 173-190 дэх тал.				

¹⁷⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйл.

Үргэлжлэл

2	“Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу хийсэн эсэх	✓	Үгүй. Дээр дурдсан тайланд “Дээрх хуулийн төсөл батлагдахад хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооллыг хийхдээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримталсан болно” гэсэн мэдэгдэл байгаа ч тус аргачлалын¹⁷⁸ зорилгыг хангаж, холбогдох аргачлалыг ашиглаагүй байгаа нь тайлангийн бүтэц, агуулгаас илт байна. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 173-190 дэх тал.
3	Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцсон эсэх	✓	Тайланд энэ төрлийн мэдээлэл байхгүй. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 173-190 дэх тал.

¹⁷⁸ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал.

Үргэлжлэл

4	Иргэнд үүсэх зардлыг тооцсон эсэх	✓	Тайланд энэ төрлийн мэдээлэл байхгүй. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 173-190 дэх тал.
5	Төрийн байгууллагын зардлыг тооцсон эсэх	✓	Тийм. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол”-д зөвхөн сонгуулийн байгууллагаас сонгууль зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны зардлыг тооцоолсон байна. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 173-190 дэх тал.

Үргэлжлэл	
6	Зардал тус бүрийг тооцож, ачааллыг бууруулах санал боловсруулсан эсэх ✓ Үгүй. Тайлангаас харахад зардлын төрлийг жагсаан бичсэнээс биш, ачааллыг багасгах санал, дүгнэлт бүхий хэсэг алга байна. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зардлын тооцоолол, хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 173-190 дэх тал.

Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар

Хэсэг 4.

Төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх

Дүгнэлт, тайлбар:

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 1.3 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хууль хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино” гэжээ. Тус аргачлалын 2.2 дахь хэсэгт төслийн үр нөлөөг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтэд “зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой болон хүлээн зөвшөөрөгдөх байдал, зардал, харилцан уялдаа” зэрэг төрлийг жагсаасан байна. Хуулийн төслөөр хийгдсэн үр нөлөөний үнэлгээний тайланд “зардал” гэсэн шалгуураас бусад шалгуур үзүүлэлт бүрийг сонгон авч “ойлгомжтой байдал” “харилцан уялдаа” гэсэн шалгуураар хуулийн төслийг бүхэлд нь, “зорилгод хүрэх байдал” шалгуураар есөн зүйлийн зарим заалт¹⁷⁹, “практикт хэрэгжих боломж” шалгуураар 30 дугаар зүйлийн 30.5-30.8 дахь хэсэг, “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуураар 79 дүгээр зүйлийн зарим хэсгийг¹⁸⁰ сонгон, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоож, тохирох шалгах хэрэгслийг тодорхойлсон байна.

¹⁷⁹ Төслийн 6, 3, 39, 40, 23, 14, 15, 16, 17 дугаар зүйлийн зарим заалт, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ” тайлан, 10 дахь тал.

¹⁸⁰ Мөн тэнд.

Үргэлжлэл

- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 1.2-т “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардлыг тооцож, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулахад энэхүү аргачлалын зорилго оршино” гэжээ. Тус хуулийн төслийн зардал тооцсон тайлангаас харахад зөвхөн төрийн байгууллагын зардал, тэр дундаа сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг л жагсаан оруулснаас бус, сонгогч буюу иргэн, хуулийн этгээдийн зардлыг тооцсон талаар мэдээлэл байхгүй байна. Ийнхүү зардал тооцох нь зөвхөн төсөв, тооцооны тухай асуудал бус харин аргачлалд¹⁸¹ дурдсан шиг “холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах” боломжтой эсэхийг тогтоох зорилготой юм. Тус тайлан нь холбогдох талуудын зардлын “ачааллыг аль болох багасгах санал боловсруулах” үндсэн зорилгын хүрээнд бус, зөвхөн сонгуулийн зарим үйл ажиллагааны төсвийг л тооцон жагсаасан төдий болжээ.

¹⁸¹ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” -ын 2.7, 3.7, 4.7 дахь хэсэг.

ТАВ. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨЛӨӨЛӨЛ, ОЛОН НИЙТЭЭР
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЖ, САНАЛ АВАХ

5.1. Төслийг олон нийтээр хэлэлцүүлж, баримтжуулан, хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргасан эсэх¹⁸²

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх	-	-	Хуулийн хувийн хэрэгт энэ талаар албан ёсны мэдээлэл байхгүй.
2	Бичгээр санал авах хэлбэрээр зохион байгуулсан эсэх	-	-	Хуулийн хувийн хэрэгт энэ талаар албан ёсны мэдээлэл байхгүй. Харин Сонгуулийн ерөнхий хорооноос хуулийн төсөлд цахимаар санал авахдаа “Хуулийн төслүүдтэй танилцаад саналаа дэд ажлын хэсгийн ges.gov.mn цахим хаягаар болон Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр ирүүлэх боломжтой” гэсэн мэдээллийг цахим хуудсандаа байрлуулсан байв. Энэ талаар Сонгуулийн ерөнхий хорооноос лавлахад тухайн үед төрийн болон төрийн бус байгууллага, улс төрийн намууд саналаа

¹⁸² Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйл.

Үргэлжлэл

албан бичгээр ирүүлж байсан бөгөөд энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны архивд хадгалагддаг байна.

Эх сурвалж:

- Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн “Хуулийн төслүүдэд санал авч байна” гэсэн гарчигтай цахим хуудасны нүүр зураг;
- Ярицлагын тэмдэглэл.

3 Уулзалт, хэлэлцүүлэг хэлбэрээр
зохион байгуулсан эсэх ✓

Тийм. Хуулийн хувийн хэрэгт энэ талаар албан ёсны мэдээлэл байхгүй. Гэсэн хэдий ч 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн ерөнхий хороо, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон УИХ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгтэй¹⁸³ хамтран хуулиудын төслийн хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулсан¹⁸⁴ байна. Тус хэлэлцүүлэгт сонгуулийн

¹⁸³ “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 195 тоот захирамж.
¹⁸⁴ Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (ges.gov.mn).

Үргэлжлэл

зохион байгуулалтын үйл ажиллагаанд үүрэг хүлээн оролцдог төрийн байгууллагууд, Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн 24 намын дарга, тэдгээрийн төлөөлөл, сонгуулийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, мониторинг хийж ажилладаг төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцсон байна.			
Эх сурвалж:			
- Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудасны мэдээ.			
4	Санал асуулга явуулах хэлбэрээр зохион байгуулсан эсэх	-	Хуулийн хувийн хэрэгт энэ талаар албан ёсны мэдээлэл байхгүй.
5	Олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах хэлбэрээр зохион байгуулсан эсэх	-	Үнэлгээний энэ асуултад мөн хариулах боломжгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т заасны дагуу “албан ёсны цахим хуудас”-нд байршуулж санал авах, мөн хуулийн 38.5.4 дэх хэсэгт заасан “олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах” хоёр агуулга нь нэг эсвэл өөр, тусдаа ойлголт болох эсэх нь эргэлзээтэй. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд ¹⁸⁵ “олон

¹⁸⁵ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 3.2.4 дэх хэсэг.

Үргэлжлэл

нийтийн цахим сүлжээгээр ¹⁸⁶ хэлэлцүүлэг явуулах тохиолдолд хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн товч танилцуулгыг тавьж, дэлгэрүүлэн танилцах боломжтой цахим холбоосыг олон нийтэд мэдээлнэ” гэснээс харахад энэ хоёр зохицуулалт өөр байхаар байна.			
6	Олон нийтийн хэлэлцүүлгийг дээрхээс өөр бусад хэлбэрээр зохион байгуулсан эсэх	-	“Бусад хэлбэр” гэдэгт утсан холбоо, алсын зайн теле хурал, холбогдох этгээдтэй ярилцлага хийх ¹⁸⁷ зэрэг хэлбэр байж болох бөгөөд энэ талаар мэдээлэл олдоогүй.
7	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх	-	Олон нийтийн хэлэлцүүлэг нэг л удаа зохион байгуулагдсан огноо нь 2018 оны 10 дугаар сарын 25, Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсаар дамжуулан санал авах ажил нь 2019 оны 5 дугаар сараас хойш байв.

¹⁸⁶ “Олон нийтийн цахим сүлжээ” гэдэгт, тухайлбал, фэйсбүүк зэрэг платформьг ойлгодог нийтлэг хандлага бий.
¹⁸⁷ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дугаар бүлгийн 7.5 дахь хэсэг.

Үргэлжлэл

8	Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар холбогдох материалыг баримтжуулж, хуулийн төслийн бүрдүүлбэрт хавсаргасан эсэх	-	-	“Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас”-нд “Олон нийтийн хэлэлцүүлэг, сайтад байршуулсан мэдээлэл, саналын товьёг хавсаргасан” ¹⁸⁸ гэсэн мэдээлэл байгаа ч хуулийн хувийн хэрэгт байгаагүй. Энэ үнэлгээ нь “олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаагүй” гэсэн хэрэг бус харин үүнийг баримтжуулсан хангалттай албан ёсны мэдээлэл байхгүйтэй холбоотой болно.
Эх сурвалж:				
- Хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 4 дэх тал.				

¹⁸⁸ Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 4 дэх тал.

5.2. Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төслийг байршуулж, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх¹⁸⁹

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль санаачлагч хуулийн төслийг цахим хуудсанд байршуулсан эсэх	✓		Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т зааснаар хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа байршуулж санал авах ёстой. Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд 2019 оны 5 дугаар сараас өргөн барих хүртэл байршуулсан ¹⁹⁰ байна. Сонгуулийн ерөнхий хороо нь холбогдох хууль тогтоомжид зааснаар “хууль санаачлагч” биш, нөгөө талаас хууль санаачлагчийн “албан ёсны цахим хуудас” гэдгийг хэрхэн ойлгох талаар Хууль тогтоомжийн тухай хуульд тодорхой бус байна.
Эх сурвалж:				
- Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн “Хуулийн төслүүдэд санал авч байна” гэсэн гарчигтай цахим хуудасны нүүр зураг;				
- Ярилцлагын тэмдэглэл.				

¹⁸⁹ Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 4 дэх тал.

¹⁹⁰ Гурван жилийн өмнөх үйл явц тул цахим хуудасны архиваас холбоосыг нь олж авах боломжгүй байв.

Үргэлжлэл

2	Хуульд заасан хугацаанд байршуулсан эсэх	✓	Энэ хэсгийн 1 дүгээр шалгах асуулгын хариултыг харна уу.
3	Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл, үзэл баримтлал, холбогдох тайлангуудыг байршуулсан эсэх	✓	Сонгуулийн ерөнхий хороо цахим хуудсандаа хуулийн төсөл, үзэл баримтлалыг санал авахаар байршуулсан ч Хууль тогтоомжийн тухай хуульд тодорхойлсон тайлангууд, тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн хувьд үр нөлөөг үнэлсэн, зардлын тооцоо хийсэн тайлангуудыг байршуулаагүй байна.
Эх сурвалж:			
- Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн “Хуулийн төслүүдэд санал авч байна” гэсэн гарчигтай цахим хуудасны нүүр зураг; - Ярилцлагын тэмдэглэл.			
4	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заасан эсэх	✓	Энэ хэсгийн 1 дүгээр шалгах асуулгын хариултыг харна уу.
5	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг хангалттай тогтоосон эсэх (15-аас доошгүй хоног)		Энэ хэсгийн 1 дүгээр шалгах асуулгын хариултыг харна уу.

Үргэлжлэл

6	Иргэн, хуулийн этгээд саналаа бичгээр өгсөн эсэх	✓	6.1 дэх хэсгийн 2 дахь шалгах асуулгын хариултыг харна уу.
7	Ирүүлсэн саналаар хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёг бэлтгэн цахим хуудсандаа нийтэлсэн эсэх	-	Эдгээр үнэлгээний асуултад хариулах боломжгүй байна. 9.1 дэх хэсгийн 11 дэх шалгах асуултыг харна уу. Харин Сонгуулийн ерөнхий хороо хуулийн төслийг цахим хуудсандаа байршуулахдаа холбогдох талуудаас ирүүлсэн саналыг уг төслийн хамт байршуулж байсан талаар мэдээлэл өгсөн.
8	Тусгагдсан санал бодит байдал дээр хууль тогтоомжийн төсөлд тусгалаа олсон эсэх	-	-
9	Саналын товъёгийг хуульд заасан хугацаанд байршуулсан эсэх (олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор)	-	-
10	Тухайн хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хүртээмжтэй хэлэлцүүлж, холбогдох оролцогч талуудын саналыг хангалттай тусгасан эсэх	-	Үнэлгээний энэ асуултад хариулах боломжгүй байна. Гэхдээ хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг 2017-2019 онд бараг гурван жил ажиллах хугацаандаа зөвхөн нэг л удаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан нь хангалтгүй, нөгөө талаас олон нийтийн хэлэлцүүлгийн бусад хэлбэрийг ашиглан санал цуглуулах ажлыг хэрхэн зохион байгуулсан, цуглуулсан саналаа хуулийн төсөлд яаж тусгасан талаар албан ёсны мэдээлэл байхгүй байна.

Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар

Хэсэг 5. Иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлж, санал авах	Дүгнэлт, тайлбар: – Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана” гэжээ. Уг заалтаас харахад энэ ажлыг хариуцах эзэн нь хууль санаачлагч байх, цаг хугацааны хувьд өргөн мэдүүлэхээс өмнө буюу 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс өмнө байх, үйл явцыг баримтжуулан бүрдүүлбэрт хавсаргахаар байна. Бодит байдал дээр холбогдох баримт бичгүүд нь хуулийн төслийн бүрдүүлбэрт хавсаргагдаагүй, хуулийн хувийн хэрэгт энэ талаар мэдээлэл байхгүй байна. “Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан” гэж байгаа ч энэ нь цөөн буюу гурван сонгуулийн ийм том, чухал хуулийн хэлэлцүүлгийг нэг удаа хийгээд орхих нь учир дутагдалтай. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг 2017-2019 онд бараг гурван жил ажиллах хугацаандаа ийнхүү зөвхөн нэг л удаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан нь хангалтгүй, нөгөө талаас олон нийтийн хэлэлцүүлгийн бусад хэлбэр ашиглан санал цуглуулах ажлыг хэрхэн зохион байгуулсан, цуглуулсан саналаа хуулийн төсөлд яаж тусгасан талаар “албан ёсны мэдээлэл” байхгүй байна. – Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2 дахь хэсэгт “Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, ...тайланг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана” гэж хариуцах эзнийг нь тодорхой заасан атал дэд ажлын хэсгийн хүрээнд буюу Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд байрлуулсан мэдээлэл л байв. Сонгуулийн ерөнхий хороо хуулийн төсөл, үзэл баримтлалыг байршуулсан ч Хууль тогтоомжийн тухай хуульд тодорхойлсон тайлангууд, тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн хувьд үр нөлөөг нь үнэлсэн, зардлын тооцоо гаргасан тайлан байршуулаагүй байна. Гэхдээ Сонгуулийн ерөнхий хороо нь “хууль санаачлагч” биш юм. Эндээс харахад хууль санаачлагчийн “албан ёсны цахим хуудас”-ыг хэрхэн ойлгох талаар Хууль тогтоомжийн тухай хуульд тодорхой зохицуулалт байхгүй байна.
--	---

ЗУРГАА. ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА,
МЭРГЭЖЛИЙН БОЛОН СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ АВАХ

6.1. Хууль санаачлагч санаачилж байгаа хууль тогтоомжийн төсөлдөө түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагаас санал авсан эсэх¹⁹¹

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон хэрэгжилтэд хяналт тавьж оролцдог төрийн байгууллагуудаас санал авсан эсэх	-	-	Үнэлэх боломжгүй байна. Хуулийн хувийн хэрэгт энэ талаар албан ёсны мэдээлэл огт байхгүй боловч үнэлгээний ажлын явцад хийсэн ярилцлага, Төрийн байгуулалтын байнгын хороо, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн нэмэлт материалд 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Татварын ерөнхий газар, Баглан хамгаалах яам, Гадаад харилцааны яам зэрэг долоон байгууллагаас санал ирүүлсэн жагсаалт байна.

¹⁹¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйл.

Үргэлжлэл

Эх сурвалж:			Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөлд холбогдох байгуулагаас ирүүлсэн санал (12 хуудас).
2	Авсан саналыг тусгасан эсэх	-	Үнэлэх боломжгүй байна. Дээрх саналуудыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар мэдээлэл байхгүй байна.
3	Тухайн хууль тогтоомжоор зохицуулах асуудлын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод зэргээс санал авсан эсэх	-	Үнэлэх боломжгүй байна. Энэ хэсгийн нэг дэх шалгах асуултад дурдсан баримтад Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам, Монголын ногоон нам, Монголын консерватив нам, Монголын хүний төлөө нам, Хөдөлмөрийн үндэсний нам, Монгол ардын хувьсгалт нам, Монголын Үндэсний ардчилсан нам, Үнэн ба зөв нам санал ирүүлжээ. Тус баримтад Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд ¹⁹² төрийн бус хоёр байгууллагын хувьд “тусгайлан өгөх саналгүй” гэсэн тэмдэглэл оруулсан байна. “Хуулийн төсөлд ирүүлсэн санал” нэртэй Төрийн байгуулалтын байнгын хорооноос ирүүлсэн бас нэг жагсаалтад “Шударга

¹⁹² Тухайн үед Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулж санал авч байсан.

Үргэлжлэл

сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээ, “Хараат бус сонголт-Иргэний оролцоо”, Сонгогчдын боловсрол төв төрийн бус байгууллага, иргэн З.Батдорж нарын хуулийн төсөлд өгсөн саналыг жагсаан, ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэсэн байх ч тухайн саналыг төсөлд тусгасан эсэх, ажлын хэсэг үүнийг хүлээн авсан эсэх талаар мэдээлэл байхгүй.

Эх сурвалж:

- Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн санал (12 хуудас);
- Төрийн байгуулалтын байнгын хорооноос илгээсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн санал (6 хуудас).

Үргэлжлэл

4	Эдгээр байгууллагын саналыг бичгээр авсан эсэх	-	-	Үнэлэх боломжгүй байна.
5	Эдгээр байгууллагын саналын хариуг албан ёсоор бичгээр өгсөн тохиолдол байгаа эсэх	-	-	Хууль тогтоомжийн тухай хуулиар ¹⁹³ дээр дурдсан байгууллагын саналыг бичгээр үйлдэх ёстой ч энэ талаар холбогдох эх сурвалж байхгүй тул эдгээр шалгах асуултад мөн хариулах боломжгүй байв. Гэхдээ үнэлгээний явцад “Ажлын хэсгээс 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр хуулиудын төсөлд санал авахаар улс төрийн 28 нам, төрийн 16 байгууллага, төрийн бус есөн байгууллагад урьдчилан хүргүүлсэн бөгөөд улс төрийн найман нам, төрийн найман байгууллага, төрийн бус хоёр байгууллагаас хуулийн төслүүдэд саналаа бичгээр ирүүлжээ” ¹⁹⁴ гэсэн мэдээлэл олж авсан ч үүнийг баталгаажуулах “албан ёсны” эх сурвалж олдоогүй болно.

¹⁹³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 39.4 дэх хэсэг.

¹⁹⁴ Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (ges.gov.mn).

Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар

Хэсэг 6.

Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах

Дүгнэлт, тайлбар:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төсөлдөө түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагаас санал авах ёстой ч энэхүү хуулийн шаардлагыг хэрхэн хангаж байгааг үнэлэх мэдээлэл хуулийн хувийн хэрэгт байгаагүй, харин холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж байхдаа Сонгуулийн ерөнхий хорооноос ажлын хэсэгт танилцуулахаар бэлдсэн жагсаалтыг олж авсан ч энэ нь хууль ёсны эсэх нь эргэлзээтэй тул үнэлгээ хийхэд ашиглах баталгаатай эх сурвалж гэж үзээгүй болно. Гэхдээ Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн хууль тогтоомжийг боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй¹⁹⁵ боловч Хууль тогтоомжийн тухай хуулиар “хууль санаачлагч” биш тул үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна.
- Хууль тогтоомжийн тухай хуулиар “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат”¹⁹⁶ гэсэн хэсэгт “хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах” гэсэн үе шатыг тодорхойлсон ч тус хуулийн 39 дүгээр зүйлд зөвхөн “Төрийн байгууллагаас санал авах” гэсэн нэр бүхий нэг л зүйл энэ үе шаттай холбоотой байна. Тиймээс “төрийн бус” бусад оролцогч талын саналыг хэрхэн, яаж авах талаар суурь зохицуулалт байхгүй гэж хэлж болохоор байна.

¹⁹⁵ 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангах дэд ажлын хэсэг” байгуулж, даргаар нь Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Ц.Болдсайханыг томилсон байна.

¹⁹⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл.

Үргэлжлэл

Түүнчлэн энэ үе шатанд хууль санаачлагч санаачилж буй хууль тогтоомжийн төсөлдөө¹⁹⁷ санал авах тухай л заасан тул Хууль тогтоомжийн тухай хуулийн долоодугаар бүлэгт байх “өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл”-д санал авах тухай зохицуулалт биш гэж ойлгож байна. Хуулийн хувийн хэрэгт байгаа баримтуудаас харахад төрийн найман байгууллага¹⁹⁸ (Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гадаад харилцааны яам, Үндэсний аудитын газар) санал ирүүлсэн байх бөгөөд эдгээр санал нь хуулийн төсөл өргөн мэдүүлсний дараа өгсөн санал байна. Эдгээр саналын зарим нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль батлагдсаны дараа ажлын хэсэгт очжээ¹⁹⁹.

- Энэ үе шатанд төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах ёстой ч хуулийн хувийн хэрэгт энэ төрлийн баримт, мэдээлэл алга. Тухайн үед “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн байгууллагууд ажлын хэсэгт саналаа хүргүүлсэн байдаг ч тэдгээр байгууллагын саналыг хуулийн хувийн хэрэгт огт хавсаргаагүй байна. Тухайлбал, Сонгогчдын боловсрол төвөөс 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр 01/19 тоот санал хүргүүлэх тухай албан бичиг (хавсралт 4 хуудас, 12 тооны санал) хүргүүлж байсан ч хуулийн хувийн хэрэгт хавсаргагдаагүй байна.

¹⁹⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 39.1 дэх хэсэг.

¹⁹⁸ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэргийн 68-116 дахь тал.

¹⁹⁹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 82 дахь тал.

Үргэлжлэл

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн эх барьсан зөвлөх Ц.Болормаагийн тайланд²⁰⁰ “Ажлын хэсэг 11 дүгээр сарын 20-ноос 12 дугаар сарын 8-ны хооронд нийт таван удаа хуралдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн 50 орчим саналаас 40 орчмыг, УИХ-ын гишүүн А.Адъяасүрэнгийн 30 саналаас 20 орчмыг, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн 30 гаруй саналаас 20 орчмыг, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн²⁰¹ зургаан багц саналаас тавыг, Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн 25 саналаас 24-ийг, Татнуулын ерөнхий газраас ирүүлсэн таван саналаас гурвыг, Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн 11 саналаас тавыг, Гадаад хэргийн яамнаас ирүүлсэн таван саналаас гурвыг, Үндэсний аудитын газраас ирүүлсэн 14 саналаас наймыг төсөлд тусгах шаардлагатай гэж үзэн, анхны хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй 71 санал, гурван багц найруулгын санал, эцсийн хэлэлцүүлгийн шатанд найман санал хэлэлцүүлэн хуульд тусгуулан баталсан” гэжээ. Эдгээр байгууллагатай зэрэгцээд төрийн бус байгууллагууд санал өгсөн хэдий ч түүнийг авч хэлэлцээгүй. Энэ нь хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, сонгуулийн үйл явцад хуулиар тодорхой чиг үүрэг, эрх хэмжээгэй оролцдог нэг тал болох төрийн бус байгууллагын саналыг хууль тогтоомжийн төсөл хэлэлцэхдээ ач холбогдол өгч авч хэлэлцдэггүй хандлага байгааг харуулж байна.

²⁰⁰ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботийн 191 дэх тал.

²⁰¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хувийн хэрэгт Улсын бүртгэлийн байгууллагаас ирүүлсэн санал байгаагүй.

ДОЛОО. ТӨСЛИЙГ ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

7.1. Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөлд Засгийн газрын санал, дүгнэлт авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, санал дүгнэлтийг нь авсан эсэх²⁰²

№	Шалгах асуулт	Хариулт	Тайлбар, үндэслэл
		тийм гүй	
1	Хууль санаачлагч санаачилсан хууль тогтоомжийн төслөө үзэл баримтлал, танилцуулга, холбогдох тайлангийн хамт санал авахаар Засгийн газарт хүргүүлсэн эсэх	✓	Тийм. Хууль санаачлагч төслөө Засгийн газрын санал, дүгнэлт авахаар хүргүүлсэн байна. Эх сурвалж: - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2102 тоот албан бичиг.

²⁰² Хууль тогтоомжийн тухай хуулийн 20, 21 дүгээр зүйл.

Үргэлжлэл

2	Засгийн газар санал дүгнэлтээ хууль санаачлагчид хүргүүлсэн эсэх	✓	Тийм. Засгийн газраас санал, дүгнэлтээ хуралдааны тэмдэглэл байдлаар хууль санаачлагчид хүргүүлсэн байна. Эх сурвалж: - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2102 тоот албан бичиг; - Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл.
3	Засгийн газар санал дүгнэлтээ хуулийн хугацаанд багтаан хүргүүлсэн эсэх (ажлын 30 өдрийн дотор)	-	Үнэлгээний ажлын хүрээнд олж авсан мэдээллийн хэмжээнд энэ асуултад хариулах боломжгүй байна. Засгийн газрын санал дүгнэлтийг хууль санаачлагч 2019 оны 7 дугаар сарын 16-нд хүлээж авсан боловч хууль санаачлагч хуулийн төслийг хэзээ хүргүүлсэн талаар мэдээлэл олдоогүй болно. Эх сурвалж: - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2102 тоот албан бичиг.

Үргэлжлэл

4	Хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцсэн эсэх ²⁰³ талаар Засгийн газрын дүгнэлт гарсан эсэх	✓	Үгүй. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр хууль санаачлагчид хүргүүлсэн байна. Тус тэмдэглэлд “...хуулийн төслийг хэлэлцээд зарчмын хувьд дэмжиж” гэсэн ерөнхий дүгнэлт байх бөгөөд тухайн хуулийн төсөлд холбогдуулан найман санал уламжилжээ. Эдгээр санал нь сонгогчдын санал авах үйл явцтай холбоотой болохоос төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцсэн эсэх талаарх аливаа дүгнэлт, мэдээлэл агуулаагүй байна. Эх сурвалж: - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2102 тоот албан бичиг; - Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл.
---	--	---	---

²⁰³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.9.1 дэх хэсэг.

Үргэлжлэл

5	Хууль тогтоомжийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд ²⁰⁴ заасан шаардлагыг хангасан эсэх талаар Засгийн газрын дүгнэлт байгаа эсэх	✓	Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 10 дахь хэсэгт “Төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн, хуулийн төсөл хоорондын давхардал, зөрчлийг арилгаж төслийн боловсруулалтыг сайжруулах нь зүйтэй” гэсэн байгаа ч ямар давхардал, зөрчил байгааг тодорхойлоогүй байна. Тэмдэглэлээр өгсөн саналуудын дийлэнх нь хуулийн төсөлд нэмж оруулах санал байна. Эх сурвалж: - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2102 тоот албан бичиг; - Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл.
6	Дээр дурдсан асуудлаар гаргасан Засгийн газрын санал, дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулсан эсэх	-	Хууль тогтоомжийн тухай хуулиар ²⁰⁵ энэ нь “...төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцээгүй, энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан” тохиолдолд УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулах тухай зохицуулалт байна.

²⁰⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.9.3 дахь хэсэг.

²⁰⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.13 дахь хэсэг.

Үргэлжлэл

Засгийн газраас “...хуулийн төслийг хэлэлцээд зарчмын хувьд дэмжиж” гэсэн ерөнхий дүгнэлт гаргасан байх тул энэ асуултад хариулах боломжгүй байна. Түүнчлэн тус хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы хуралдааны тэмдэглэлтэй танилцахад энэ талаар мэдээлэл байгаагүй болно.

Эх сурвалж:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2102 тоот албан бичиг;
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл;
- УИХ-ын чуулганы 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 53-59 дэх тал;
- УИХ-ын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 107-136 дахь тал;
- УИХ-ын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 53-64 дэх тал.

Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар

Хэсэг 7.

Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

Дүгнэлт, тайлбар:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.9-д зааснаар Засгийн газрын санал, дүгнэлтэд тухайн хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэж байгаа эсэх, тухайн хууль тогтоомжийн төсөл Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх асуудлыг тусгасан байх ёстой. Энэ санал, дүгнэлт “Засгийн газрын хуралдааны тэмдэглэл” байдлаар гарсан байх бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцсэн эсэх талаарх дүгнэлт, мэдээлэл байхгүй, мөн “Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн сайжруулах” гэсэн байгаа ч аль хэсэг нь зөрчигдсөн, нийцэхгүй байгаа талаар нарийн, тодорхой асуудал тусгагдаагүй байна гэж үзлээ.

НАЙМ. ТӨСЛИЙН БҮРДҮҮЛБЭРИЙГ ХАНГАЖ, УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

8.1. Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт дараах баримт бичгүүд байгаа эсэх²⁰⁶

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэх тухай хууль санаачлагчийн албан бичиг байгаа эсэх	✓		Тийм. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 7 дахь тал.
2	Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал байгаа эсэх	✓		Тийм. Эх сурвалж: - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 10-12 дахь тал.

²⁰⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйл.

Үргэлжлэл

3	Хууль тогтоомжийн төслийн танилцуулга байгаа эсэх	✓	Тийм. Эх сурвалж: - Хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 13-14 дэх тал.
4	Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан байгаа эсэх	✓	Үгүй. Эх сурвалж: - Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал хамаарахааргүй байна гэж үзсэн ²⁰⁷ ; - Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан байхгүй ²⁰⁸ .
5	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан байгаа эсэх	✓	Тийм. Эх сурвалж: - Хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 117-172 дахь тал.
6	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан байгаа эсэх	✓	Тийм. Эх сурвалж: - Хуулийн хувийн хэргийн 4 дүгээр ботгийн 173-190 дэх тал.

²⁰⁷ “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” гэсэн 2 дугаар хэсгийг харна уу.

²⁰⁸ Мөн тэнд.

Үргэлжлэл

7	Тухайн хуулийн төслийг дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл байгаа эсэх	✓	Тийм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл.
Эх сурвалж: - Хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботийн 4 дэх тал; - УИХ-ын чуулганы 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.			
8	Засгийн газрын санал, дүгнэлт байгаа эсэх	✓	Тийм. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл хэлбэрээр байна.
Эх сурвалж: - Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл, хуулийн хувийн хэргийн 3 дугаар ботийн 76-78 дахь тал.			

Үргэлжлэл	
9	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвлөмж байгаа эсэх - Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлсэн эсэх²⁰⁹ талаарх мэдээлэл олдоогүй. Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж болно²¹⁰ гэсэн заалт нь заавал байх шалгуур биш байна.
10	Дээрх баримт бичгийн цахим хувь байгаа эсэх ✓ Тийм. Эх сурвалж: - Хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 5 дахь тал.

²⁰⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.1.8 дахь заалт.

²¹⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.2 дахь хэсэг.

Үргэлжлэл

11	Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товьёг байгаа эсэх	✓	Үгүй. “Олон нийтийн хэлэлцүүлэг, сайтад байршуулсан мэдээлэл, саналын товьёг хавсаргасан”²¹¹ мэдээлэл байгаа ч хуулийн хувийн хэрэгт байгаагүй. Гэхдээ Сонгуулийн ерөнхий хорооноос хуулийн төсөлд санал авч байх үед оролцогч талуудаас ирсэн саналыг нэгтгэн, хуулийн төсөлд тусгасан эсэхийг үндэслэлийн хамт нэгтгэн жагсаалт гаргасан байх бөгөөд нийт 410 саналаас 339-ийг хүлээн авч, 71 саналыг аваагүй²¹² гэсэн байгаа ч энэ нь албан ёсны гэж үзэх боломжгүй байлаа. Эх сурвалж: - Хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 4 дэх тал.
----	---	---	---

²¹¹ Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 4 дэх тал.

²¹² Төрийн байгуулалтын байнгын хорооноос илтээсэн “Хуулийн төсөлд ирүүлсэн санал” гэсэн нэртэй Excel файлаас авав.

8.2. Хууль тогтоомжийн төслийг хуульд заасан шаардлагын дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх²¹³

№	Шалгах асуулт	Хариулт		Тайлбар, үндэслэл
		тийм	үгүй	
1	Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, төслийг УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлсэн эсэх	✓		Тийм. Хууль санаачлагч төслийн бүрдүүлбэрийг хангаж, хянуулахаар УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 15 цаг 52 минутад хүргүүлж, 16 цаг 40 минутад “бүрдүүлбэрийг хангасан” гэж үзсэн байна.
Эх сурвалж:				
- “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх хугацааг товлосон тухай” хууль санаачлагчийн 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 12856 тоот албан бичиг;				
- Төслийн бүрдүүлбэр хянуулахаар хууль санаачлагчаас ирүүлсэн 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 12923 тоот албан бичиг;				
- Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр богийн 4 дэх тал.				

²¹³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйл.

Үргэлжлэл

2	УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга шаардлага хангасан төслийг УИХ-ын даргад танилцуулан, УИХ-ын даргад өргөн мэдүүлэхээр хугацааг товлосон эсэх	✓	Тийм. Төсөл өргөн мэдүүлэх хугацааг УИХ-ын даргаас 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 16 цаг 5 минут байхаар товлосон байна. Эх сурвалж: - УИХ-д өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 4 дэх тал.
3	Товлосон хугацааг хууль санаачлагчид албан бичгээр мэдэгдсэн эсэх	✓	Үгүй. Цуглуулсан мэдээллийн хувьд авч үзэхэд хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр товлосон хугацааг “албан бичгээр мэдэгдэх”²¹⁴ хуулийн зохицуулалт хэрэгжээгүй байна. Тухайлбал, товыг хууль санаачлагчид 266455 дугаарын утсаар 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдөр 15.00 цагт мэдэгдсэн гэсэн тэмдэглэл байна. Эх сурвалж: - УИХ-д өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэрийг хянах хяналтын хуудас, хуулийн хувийн хэргийн 1 дүгээр ботгийн 4 дэх тал.

²¹⁴ Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.4.

Хэсгийн нэгдсэн дүгнэлт, тайлбар

Хэсэг 8.

Төслийн бүрдүүлбэрийг хангаж, УИХ-д өргөн мэдүүлэх

Дүгнэлт, тайлбар:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд “Хууль тогтоомжийн бүрдүүлбэр” буюу УИХ-д өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд хавсаргах баримт бичгийг жагсаасан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн бүрдүүлбэрээс “Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товьёг” байхгүй байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн²¹⁵ зорилго болох “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, ...замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино” гэсэн үзэл баримтлал гажуудахад хүрэх талтай. Хуулийн төслийн бүрдүүлбэрийн ийм чухал баримт бичиг нь байхгүй агал Хууль тогтоомжийн тухай хуульд²¹⁶ заасны дагуу шаардлага хангасан эсэхийг хянаж, шаардлага хангуулах арга хэмжээ авалгүй “бүрдүүлбэр хангасан” гэж үзсэн байна.

²¹⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл.

²¹⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.2, 41.3 дахь хэсэг.

ЕС. НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

№	Хэсэг	Нэр	Үнэлгээ				
			1	2	3	4	5
1	Нэг	Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх	+				
2	Хоёр	Төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлах	+				
3	Гурав	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах		+			
4	Дөрөв	Төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх			+		
5	Тав	Иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлж, санал авах		+			
6	Зургаа	Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал авах		+			
7	Долоо	Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх				+	
8	Найм	Төслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх				+	
9	Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн нэгдсэн (дундаж) үнэлгээ:		2.3 буюу “хангалтгүй”				

ISBN 978-9919-9840-0-7



9 789919 984007